

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН
ХЭРЭГЖИЛТ /2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР/**

2024.10.30

Есөнзүйл сум

ХБТББ-т тусгагдсан Зорилт, үйл ажиллагаа	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Нийт хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Суурь түвшин	Зорилтот түвшин, үр дүн /хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр/ 2024 он			Хүрсэн үр дүн	Хөрөгжилтийн хувь
							Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв (сая.төг)	Төсвийн гүйцэтгэл (сая.төг)		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
НЭГ. ХҮНИЙ ХӨГЖИЛ											
1.1.ҮНДЭСНИЙ БАХАРХАЛ, ӨВ СОЁЛ											
Эх хэл, соёл, ёс заншлаа дээдэлсэн эх оронч үзэлтэй эв нэгдлийг эрхэмлэсэн иргэнийг төлөвшүүлэн хөгжүүлж, түүх, соёлын өвөө хамгаалан, үндэсний бахархлаа түгээн дэлгэрүүлж, соёл, урлагийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	2	“Цахим соёл”, “Соёлын өв-Хөгжлийн дархлаа”, “Бүх нийтийн соёлын боловсрол” зэрэг арга хэмжээг хэрэгжүүлж, орон нутгийн соёл, урлагийн үйлчилгээнд иргэдийн оролцоо, цахим орчин дахь үндэсний соёлын нөлөөг нэмэгдүүлнэ.	2020-2024	Соёлын төв	30.0	18.0 мян				Есөнзүйл сумын Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн А/42 дугаар захирамжийн дагуу “Угийн бичиг хөтлөлтийг эрчимжүүлэх ажлын хэсгийг болон үйл ажлын төлөвлөгөөг гарган батлуулсан. 2021 оны 03 дугаар сарын 20-ны өдөр ажлын хэсгийнхэн “Угийн бичиг”-ийн сургалтанд хамрагдаж өөрсдийн байгууллагуудад сургалтыг зохион байгуулж ажилласан. 2021 оны 05 сарын 03-ны өдөр ажлын хэсгийн ахлагч Т.Нарангэрэл бусад байгууллагуудад “Угийн бичиг хөтлөх ажлыг эрчимжүүлэх тухай” албан тоотыг хүргүүлж одоогийн байдлаар төрийн байгууллагууд угийн бичгээ хөтлөж хураалгасан байна. Соёлын өв хөгжлийн	90

									хэвшүүлэх ажлыг зохион байгуулж төсөвт байгууллага, ард иргэд угийн бичгийн үзэсгэлэн гаргаж үзэсгэлд хамт олноороо амжилттай оролцсон болон үлгэр жишээ дээд үе угийн бичгээ хөтөлсөн иргэдийг шагнаж урамшуулсан.	
3	Соёлын биет болон биет бус өвийг хадгалах, хамгаалах ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлж, соёлын өвийн эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх ажлыг хууль хяналтын байгууллагатай хамтран зохион байгуулж, Эрдэнэзуу, Шанхын хийдийг улсын хамгаалалтад авах ажлыг судалж шийдвэрлэнэ.	2020 2024	Соёлын төв	168.0	Орон нутгийн төсөв	18.0 мянга	/Цахим арга хэмжээнд хамрагдсан хүний тоо/		Нутгийн онцлогтой өвийг хамгаалж “Соёлын өв хөгжлийн дархлаа” форумас гаргасан “Өв хамгаалагч” сарын аяны хүрээнд Засаг даргын тамгын газар Хэсгийн төлөөлөгч, ЕБС-ийн Түүхийн хичээлийн багш, Байгаль хамгаалагч, хуулийн мэргэжилтэн, соёлын өвийг хамгаалагч гэрээт харуулуудтай хамтран төлөвлөгөө гарган төлөвлөгөөний дагуу суманд байгаа өвийг хамгаалах, сэргээн засварлах, хаягжуулах, хайсжуулах, Соёлын өвийн эсрэг гэмт хэргийг бууруулах чадавхийг дээшлүүлэх, соёлын өвийн боловсрол олгох, сумын хэмжээний 20 гаруй хамгаалагчдад “Соёлын өв хамгаалагч” үнэмлэх олгох ажлыг зохион байгуулж байна. Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд орон нутгийн соёл, хууль сахиулах байгууллага, соёлын өвлөн уламжлагч, өв хамгаалагч нарын хамтын ажиллагааг сайжруулах иргэд олон нийтийн өвийн боловсролыг дээшлүүлж соён гэгээрүүлэх “Өв хамгаалагч” аяныг сумын хэмжээнд зохион байгуулж нийт 22 өв хамгаалагч үүрэг гүйцэтгэн ажиллаж байгаа бөгөөд энэхүү аяны хүрээнд тэдгээрийн	100

									багийн Засаг дарга болон Соёлын төвийн эрхлэгч, гэрээт харуулын үүрэг гүйцэтгэгчийн хооронд хийгддэг гурвалсан гэрээг жил болгон шинэчлэн байгуулж үнэмлэхжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллаж байна. Мөн гэрээт харуулуудын тайлан мэдээг авсан. Гэрээт харуулуудад жилд 1 удаа 100.000 төгрөгний урамшуулал олгон ажиллаж байна. -2023 онд төсвийн өөрчлөлтөөс шалтгаалан гэрээт харуулуудад урамшуулал олгогдоогүй. 2024 онд Соёлын биет бус өвийн цахим системд соёлын өвлөн уламжлагч 5 том хүн 1 хүүхдийг бүртгэж, Өвөрхангай аймгийн Соёл урлагийн газартай хамтран ажилласан байна. Есөнзүйл сумын хэмжээнд Ардын аман өвийг тээгч, уртын дууг дуулж буй хүмүүс илүү давамгайлж байна.	
Зорилт 2. Соёл, урлагийн байгууллагын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, соёлын үйлдвэрлэлийг дэмжих замаар үйлчилгээний чанар, хүртээмжийг өргөжүүлэн, мэргэжлийн хүний нөөцөөр хангана.	5	Өлзийт, Баян-Өндөр, Нарийнтээл сумдын Соёлын төвийг засварлан өргөтгөж, Соёлын төвүүдийн тавилга, техник, хэрэгслийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн, Хайрхандулаан, Есөнзүйл сумдын Соёлын төвийн дотор тохижилт, техник хэрэгслийн хүчин чадлыг сайжруулна.	2020 2024	Соёлын төв	2.0 Тэрбум Улсын төсөв	6 Хөрөнгө оруулалт хийгдсэн байгууллагын тоо			Байгууллагын жил бүрийн урсгал засварын зардлаар дотор тохижилт хийгдэж явагддаг. Есөнзүйл сумын номын санд жил бүр 500000 төгрөгний номын баяжилт хийгддэг. Орон нутаг хөгжүүлэх сангаас 2 сая төгрөгний хандив үзүүлж 119 шинэ номын баяжилт хийгдсэн. "lib4u" программыг нэвтрүүлж цахим программд 5000 ном бүртгэлжүүлэн иргэд болон сурагчдад үйлчилгээ үзүүлж байна. -2021 онд соёлын яамны хөрөнгө оруулалтаар суурин компьютер, прентер, зөөврийн компьютер 3.639.900 төгрөг. Номын сангийн 2	90

										<p>ширээ, 4 сандал, 2 тавиур 2.026.190 төгрөгөөр шийдүүлсэн.</p> <p>-2022 онд улсын төсөв 18.986.000 төгрөгөөр тайзны автомат хөшиг, Номын сангийн компьютер 2.253.958 төгрөгөөр авч байршуулсан. Соёлын яамны хөрөнгө оруулалтаар номын сангийн 16 ширхэг сандал, 8 ширхэг ширээ 1.161.500 төгрөгөөр авч байршуулан үйл ажиллагаагаа явуулж байна.</p> <p>- 2023 оны Орон нутгийн хөгжлийн сангийн 11 сая төгрөгөөр мэргэжлийн камер, 9 сая төгрөгөөр заалны гэрэлтүүлэг, Номын сангийн 119 ширхэг номыг 2.000.000 төгрөгөөр шийдүүлэн номын санд байршуулсан байна. Соёлын яамны хөрөнгө оруулалтаар 4.692.460 төсвөөр номын санд 8 ширхэг номын тавиурыг авч байршуулсан байна. Үр дүнд суурилсан эжмжлт санхүүжилтээр караокений машин 2.700.000, хурлын 1 ширээ, 7 сандал 1.500.000, Тоос сорогч 440000 төгрөгөөр авч албан хаагчдын ажиллах нөхцөл нийгмийн баталгааг ханган ажиллаж байна.</p> <p>2024 онд Соёлын яамны хөрөнгө оруулалтаар суурин компьютер 1, даралтат хөгжим 1, зөөврийн компьютер 1 нийт 8.174.414 төсөв.</p> <p>-Орон нутгийн хөгжлийн сангаас 19.706.000 төгрөгний акустик доторлогоо хийгдэж дууссан.</p>
--	--	--	--	--	--	--	--	--	--	---

<p>\\Зорилт 3. Орон нутгийн соёл, урлагийн үйл ажиллагааны менежментийг сайжруулж, гадаад харилцааг хөгжүүлнэ.</p>	<p>1</p>	<p>Иргэдэд зайны болон нүүдлийн соёл, урлагийн үйлчилгээг хүргэж, зарим сумдын Соёлын төвүүдийг соёлын өв хариуцсан ажилтантай болгоно.</p>	<p>2020 2024</p>	<p>Соёлын төв</p>	<p>68.0 сая</p> <p>Орон Нутгийн төсөв</p>	<p>1</p> <p>Соёлын өвийн ажилтны тоо</p>		<p>Цахим орчинд “Ковид цар тахлын” үеэр хөгжим, дуу, бүжгийн багш нар хүүхдүүд болон насанд хүрэгчдэд дугуйлангийн багш нар цахимаар ажилласан. Мөн алслагдсан бригадын иргэдэд соёл урлагийн явуулын сургалтад зохион байгуулагдсан. Соёлын өвийн ажилтанг гэрээгээр ажиллуулж байна. Соёлын төвийн дэргэдэх дугуйлангийн 56 хүүхдэд цахимаар хүрч үйлчилсэн байгууллагын эдийн засаг цаг хугацааг хэмнэж ажиллаж байна. Соёлын төвийн пэйж хуудсандаа соёл, урлагийн үйл ажиллагаагаа тавин цаг алдалгүй мэдээ мэдээллийг иргэд олон нийтэд хүргэж байгаа. Багуудын өдөрлөг, УБ хот болон аймаг руу соёл урлагийн үйлчилгээг 300 гаруй том хүн 100 гаруй хүүхдэд хүрч үзүүлсэн . Хөгжим, дуу, бүжгийн багш нар дугуйлан байнгын хичээллүүлэн жилд 2-3 удаа тайлан тоглолтыг хийн иргэдэд хүргэн ажиллаж байна.</p> <p>-2024 онд Улаанбаатар хотод нээлтээ хийж буй кинонуудыг цаг алдалгүй сум орон нутагтаа зэрэгцүүлэн гаргаж байгаа дэвшилтэд ажлыг нэвтрүүлэн цахимаар билетын борлуулалтыг хийж T-Entertainment-тай хамтран ажиллаж байна.</p> <p>-Жил бүр зүүн бүсийн нөхөрсөг уулзалт тэмцээн зохион байгуулагддагийн хүрээнд тухайн сумтайгаа хамтарсан тоглолтыг зохион байгуулж хэвшсэн.</p>	<p>90</p>
--	----------	---	----------------------	-------------------	---	--	--	--	-----------

										олондоо хүргэсэн. “ZANABAZAR ART FESTIVAL”-д 2021-2022 онд олон улсын фестивалд оролцож олон улсын болон нутгийн урчуудыг таниулж ажиллалаа.	
Бүлгийн дүн										95%	
1.2.ЭРҮҮЛ МЭНД											
Зорилт Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг нэвтрүүлэн, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.	1.	Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх сургалт, сурталчилгааг зохион байгуулж, иргэн бүр урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд тогтмол хамрагдах нөхцөлийг сайжруулж, эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ.	2021 2024	ЭМТ	1	Нийт үзлэгт урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь-25				ЭМС-ын 2017 оны 471 дугаар тушаал болон “Эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, мэдээлэл сургалт сурталчилгааны үндэсний стратеги дагуу хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох сургалтын төлөвлөгөөтэй. Сургалт бүрийн хөтөлбөрийг боловсруулсан. Чихрийн шижин өвчин, Амны хөндийн эрүүл мэнд, Зүрх судасны өвчин, Нөхөн үржихүйн эрүүл мэнд, Осол гэмтэл, БЗДХ, Томуу, томуу төст өвчин, Архины хор уршиг, тамхины хэрэглээ, мансууруулах бодисын хэрэглээг бууруулах сэдвээр мэдээлэл сургалт сурталчилгаа хийсэн бүртгэлтэй байна. Сургалтын үр дүнд иргэдийн эрүүл мэндийн боловсрол 50% нэмэгдсэн. Нийт 12 удаагийн сургалтанд 398 хүн хамрагдаад байна. 2024 онд иргэдийг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх мэдлэг олгох, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн мэдээлэл сургалт сурталчилгаа нь төлөвлөгөөтэй, төлөвлөгөөний дагуу хийх ажлыг тухай бүр нь удирдамж гарган хэрэгжүүлж байна. Төлөвлөгөө удирдамжийг Ахмад настан,	100

										<p>хөгжлийн бэрхшээлтэй иргэд , хөхүүл болон жирэмсэн ээжүүд хэвтэн эмчлүүлэгч, хүүхэд гэх мэтчилэн зорилтод бүлэгт чиглүүлэн сургалтыг тахимын болон зочин хэлбэрээр хүргэж байна. Үүнд жирэмсэн 28 ээжид жирэмсний хяналт, давтан үзлэгийн ач холбогдол, 80 хөхүүл ээжид 0-6 сар хүртэл эхийн сүүгээр дагнан хооллох, 6-24 сар хүртэл нэмэгдэл хоолыг зөв бэлтгэн өгөх, 207 ахмад настанд эмийн зохистой хэрэглээ, цусны даралтын эмийг тогтмол ууж хэвших талаар, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон асран хамгаалагч нарт эмийн зохистой хэрэглээ, гар сарвууны болон хөдөлгөөний далайцыг нэмэгдүүлэх, 5 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд Эрүүл хооллолт гэж юу вэ?, Хөдөлгөөний ач холбогдол , ЕБС-ийн сурагчдад Электрон болон утаад тамхины хор уршиг, өглөөний цайны ач холбогдол, Салхин цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх, бэлгийн бойжилт, бэлгийн ариун цэвэр, зөвхөн оксидуудад сарын тэмдгийн үеийн ариун цэвэр, Гарын ариун цэвэр, Ундны усны эрүүл ахуй, усаа хайрлая, осол гэмтлээс сэргийлье зэрэг сэдвүүдээр сургалт хийж 1087 хүүхдийг хамруулсан байна. Иргэдэд хуванцар савны хэрэглээний талаар зочин мэдээллийг хийж 109 өрхийн 318 хүнд мэдээлэл хийсэн.</p>
--	--	--	--	--	--	--	--	--	--	---

									Иргэд бүх сувгаар зориулалтын бус хуванцар савны зөв хэрэглээний талаар мэдээллийг авснаар тэдний зориулалтын бус хуванцар савыг хэрэглэхгүй байх хандлагын түвшин 30% иар нэмэгдэж, ган болон хүнсний зориулалтын хуванцар савыг хэрэглэж байгаа нь иргэд эрүүл амьдралын хэв маягт алхам алхамаар ойртож байгаа нь харагдаж байна. Ахмадын хорооны дарга О.Хандмаагаар ахлуусан 15-30 ахмад настан болон иргэд хөдөлгөөний ач холбогдлыг ойлгож, өглөөний алхалт, хөдөлгөөний идэвхийг нэмэгдүүлэх дасгалыг ахмадын байрны тоног төхөөрөмжийг түшиглэн хийж хэвшээд байгаа.	
2	Иргэн бүрийг өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хорт хавдрын 7 төрөл, артерийн даралт ихсэх, чихрийн шижингийн эрт илрүүлгийн эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд тогтмол хамруулна.	2021 2024	ЭМТ	2 238.0 са	7 хавдрын эрт илрүүлгийн хувь -42.4 АГ-ийн эрт илрүүлгийн хувь 92,0 ЧШ-ийн эрт илрүүлгийн хувь 93.0			Халдварт, Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэгийг эрүүл мэндийн төв нь дараах ажлыг зохион байгуулж ажиллаа. 1. Артерийн даралт ихсэх, чихрийн шижин-2 хэв шинжит өвчний эрт илрүүлгийн үзлэгийг зохион байгуулж нийт хамрагдвал зохих 1008-987 иргэдийн 97,9%-тай байна. 2. Мөн артерийн даралт ихсэх өвчин чихрийн шижин өвчний талаар эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалт Өвөрхангай аймагт 3 удаа тус бүр 3-5 хоногоор зохион байгуулагдсан ба тухай бүрд нь 2 эмч мэргэжилтнүүдээ хамруулан мэдлэг боловсролыг нь дээшлүүлэн ажилласан.	90	

									3. Эрүүл мэндийн газраас Халдварт, Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх хяналт үнэлгээний баг манай эрүүл мэндийн төв дээр ажиллаж хангалттай дүнтэй үнэлэгдсэн. 4. Эрүүл мэндийн төвийн 4 багийн эмч нар артерийн даралт ихсэх өвчин чихрийн шижин өвчнийг тусгай программд шивж хяналтаа сайжруулаад байна.	
3	Иргэдийн дунд эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх, халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд: -Хүн амын зохистой хоололт, илүүдэл жин, таргалалттай тэмцэх, давсны хэрэглээг бууруулах арга хэмжээ	2021 2024	ЭМТ	22.0 сая	Илүүдэл жинтэй хүн амын хувь-53.5 Давсны хэрэглээг бууруулсан аж ахуйн нэгжийн тоо-62			Эрүүл мэндийн төв Хүн амын зохистой хоололт, илүүдэл жин, таргалалттай тэмцэх, зорилгоор сумын нийт 100 өрхөөс давсны хэрэглээний талаар судалгаа авч, судалгааны явцад нийт өрхийн 432 иргэнд давсны зохистой хэрэглээ болон хоногийн шаардлагатай хэмжээ , давсны ач холбогдол хор нөлөө зэргийн талаар мэдлэг олгох сургалт сурталчилгааны материал тараан ажилласан. Мөн Энэ жилдээ эрүүл жиндээ аянд нэгдэн эмнэлгийн ажилчдадаа өглөө бүр дасгал хөдөлгөөнд хамруулан ахмадууд болон бусад байгууллагуудын нийт 100 гаруй хүмүүсийг хамруулан дасгал хөдөлгөөн, ажлын байрны идэвхитэй хөдөлгөөний сургалт сурталчилгаа зохион байгуулсан.	100	
4	Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хянах, бууруулах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:	2021 2024	ЭМТ	255.0	Эрүүл, аюулгүй, ногоон хот болох төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь-20			Тэмбүү өвчний илрүүлэх үзлэг шинжилгээг зохион байгуулах шинжилгээг зохион байгуулах ажлын хэсгийг эрхлэгч эмчийн тушаалаар 9 хүний бүрэлдэхүүнтэй томилон ажилж байна. Шаардлагатай урвалж оношлуур, эм тарианы жагсаалт,	90	

		<p>-Орчны эрүүл мэндийг сайжруулах арга хэмжээ</p> <p>-Сүрьеэ өвчинтэй тэмцэх</p> <p>-БЗХӨ/Дох/Тэмбүү өвчнийг бууруулах арга хэмжээ</p> <p>-Томуу, томуу төст өвчнийг бууруулах арга хэмжээ</p> <p>-“Элэг бүтэн Монгол” арга хэмжээ</p> <p>-Хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах арга хэмжээ</p>				<p>Бүх Хэлбэрийн сүрьеэгийн илрүүлэлтийн хувь-45</p> <p>Сүрьеэгийн ннас баралтын түвшин 3,5</p>			<p>шаардлагатай төвийн тооцоолол жилд дунджаар 1,2 сая төгрөг тусгахаар гарсан байна.Тэмбүү тест 300, Дох-ын тест 150, 2019 оны 10 сарын 16 ны өдрөөс эхлэн тэмбүүгийн халдварыг эрт илрүүлэх, мөн БЗДХ-ын өвчтэй илрэгсдийг хавьтагчийн хамт эмчлэх, хяналтанд авах зэргийг эх баригчийг албан тушаалын тодорхойлолтонд оруулж хариуцуулан ажиллаж байна.</p> <p>Жирэмсэний хяналтанд орсон 30 жирэмсэн ДОХ/БЗДХ-ийн шинжилгээнд 100 хувь мөн 32 долоо хоногтой давтан хамруулж байна. 2023 оны 11 сарын байдлаар БЗДХ илрээгүй байна. Тэмбүү илрүүлэх сорилд эерэг гарсан тохиолдол бүрийг БОЭТ-н БЗДХ-ын кабинетэд илгээж ТРНА-титр тодорхойлуулан эмчилгээнд хамруулж, сарын дараа давтан шинжилгээнд хамруулж байна.</p> <p>Томуу, томуу төст өвчнийг бууруулах зорилгоор зорилтот насны иргэдийг томуугын вакцинжуулалтанд хамруулсан. Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээллийг цахимаар явуулдаг. Томуу, томуу төст өвчнийг бууруулах зорилгоор 2-11 насны 214, жирэмсэн 6 иргэнийг томуугын вакцинжуулалтанд хамруулсан. Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж мэдээллийг байгууллагын хуудсанд байршуулсан.</p>
--	--	--	--	--	--	---	--	--	--

										<p>Хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах зорилгоор хуванцар савны хэрэглээг бууруулж, Эко ундны усны савыг нэмэгдүүлэх зорилгоор сумын хүнс хөдөө аж ахуй хариуцсан мэргэжилтэнтэй хамтран гал тогоо бүхий газрууд болон айл өрхийн дунд уралдаан зарлаж удирдамжийг хүргүүлээд байна. Сүрьеэ-Сүрьеэгийн өвчлөлөөс урьдчилан сэргийлэх үзлэгийг эрсдэлтэй ард иргэд зохион байгуулж ажиллаа. Үзлэгт нийт 89 хүн хамрагдсан. Есөнзүйл суманд одоогийн байдалаар сүрьеэтэй иргэн байхгүй. Сүрьеэгийн өвчлөлөөс урьдчилан сэргийлэх талаар сургалт сурталчилгааг ард иргэд болон эмч эмнэлгийн ажилчид, хэвтэн эмчлүүлэгчидэд дотоод сургалт зохион байгууллаа. Сургалтын үеэр гарын авлаг материалыг иргэдэд түгээсэн. Сорьц авах хадгалах, тээвэрлэх үйл ажиллагааны мөрдөлтийг дагаж нийт одоогийн байдалаар 3 сорьц явуулаад байна. 2024 онд орчны эрүүл мэндийг сайжруулах арга хэмжээний хүрээнд 2024 оны 04 сарын 18,19-ний өдрүүдэд сумын төвийн нийтийн хог цэвэрлэгээнд иргэд, албан байгууллага, аж ахуйн нэгжүүд гарч хамтран ажилласан. Бүх байгууллагууд сумын төвийн хороолол, гудамж, талбай, голын голидролыг хариуцан авч баг хамт олноороо цэвэрлэсэн. 2024 онд хүнсний эрүүл ахуй аюулгүй</p>
--	--	--	--	--	--	--	--	--	--	---

										<p>байдлын хүрээнд хүнсний худалдаа үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд холбогдох хууль, стандартын хүрээнд хяналт шалгалтыг хийж, илэрсэн зөрчлийн шалтгаан нөхцөлийг тогтоох, зөрчлийг арилгуулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг дотоодоо бууруулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, хүнсний өргөн хэрэглээний бараа материалын нөөц, үнэ ханшийн мэдээлийг авах зорилгоор хяналт үнэлгээ хийлээ. Хяналт үнэлгээг Худалдаалах үйл ажиллагааны эрүүл ахуйн нөхцөл шаардлагыг шалгах хуудас, “Худалдаалах үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас”-ны 5 бүлэг 41 шалгуур үзүүлэлтээр хяналт шалгалт хийхэд Гадна орчин, барилга байгууламжийн эрсдэлийн үнэлгээ, дундажаар бага эрсдэлтэй, Ажиллагсдын ариун цэвэр, эрүүл ахуйн эрсдэлийн үнэлгээ, дундажаар бага эрсдэлтэй, Угаалга, цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн эрсдэлийн үнэлгээ, дундажаар дунд эрсдэлтэй, бүтээгдэхүүний аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, дундажаар бага эрсдэлтэй, Бүтээгдэхүүний хадгалалт, борлуулалт, тээвэрлэлтийн эрсдэлийн үнэлгээ, дундажаар бага эрсдэлтэй байлаа. Сумын төвийн нийт өрхийн 00-ын судалгааг авахад 39 гудамж, 256 хашаанд өвөлдөө 250 өрх зундаа 223 өрх амьдардаг. Нийт 256</p>
--	--	--	--	--	--	--	--	--	--	---

										<p>хашаанд 246 ширхэг 00-ыг ашиглаж байгаагаас 153 ш 00-ыг 5-8 жил, 46 ш 00-ыг 3-5 жил, 31 ш 00-ыг 1-3, 16 ш 00-ыг 06 сараас-1 жилээс илүү ашиглах боломжгүй байна. 197 хашаанд булагдсан хуучин 00 -ын нүх 2-3 байна. Эрүүл мэндийн төвийн гадаад орчинд чанарын багийн ахлагчтай хамтран хийлээ. Гадаад орчны үнэлгээнд хаягжилтын 2, гадаад орчны 11 асуумжаар “тийм үгүй” гэсэн хариулттайгаар авлаа. 12 асуултын дагуу үнэлж, эрсдлийг илрүүлэн илэрсэн эрсдлийг арилгах ажлын хүрээнд. Эмнэлгийн хашаанд байгаа ашиглагдахгүй төмөр модны үлдэгдэл, худагны дотор гаднах орчин цэгцэлж ашиглагдахгүй 2 барилгыг нурааж цэвэрлэсэн. 2024 онд хүнсний эрүүл ахуй аюулгүй байдлын хүрээнд Хүнсний худалдаа үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд холбогдох хууль, стандартын хүрээнд хяналт шалгалтыг хийж, илэрсэн зөрчлийн шалтгаан нөхцөлийг тогтоох, зөрчлийг арилгуулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг дотоодоо бууруулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, хүнсний өргөн хэрэглээний бараа материалын нөөц, үнэ ханшийн мэдээлийг авах зорилгоор ИТХ-ын ажлын албатай хамтран хяналт үнэлгээ хийлээ. Хяналт үнэлгээг Худалдаалах үйл ажиллагааны эрүүл ахуйн нөхцөл шаардлагыг шалгах хуудас, “Худалдаалах үйл</p>
--	--	--	--	--	--	--	--	--	--	---

									<p>ажиллагааг шалгах хяналтын хуудас"-ны 5 бүлэг 41 шалгуур үзүүлэлтээр хяналт шалгалт хийхэд Гадна орчин, барилга байгууламжийн эрсдэлийн үнэлгээ, дундажаар бага эрсдэлтэй, Ажиллагсдын ариун цэвэр, эрүүл ахуйн эрсдэлийн үнэлгээ, дундажаар бага эрсдэлтэй, Угаалга, цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн эрсдэлийн үнэлгээ, дундажаар дунд эрсдэлтэй, бүтээгдэхүүний аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, дундажаар бага эрсдэлтэй, Бүтээгдэхүүний хадгалалт, борлуулалт, тээвэрлэлтийн эрсдэлийн үнэлгээ, дундажаар бага эрсдэлтэй байлаа.хяналт шалгалтын мөрөөр гарсан зөрчлүүдийг тухай бүр нь зөвлөгөө өгч, мөн албан бичгээр зөвлөмж хүргүүлсэн.</p> <p>Хөдөөгийн алслагдсан баг тахилга 1 баг, Эрээний 4-р баг Хайрханы 3 багийн иргэдийг урьдчилан сэргийлэх үзлэгээр явж 15-49 насны иргэдийг БЗХӨ/Дох/Тэмбүү хурдавчилсан оношлуураар нийт 220 иргэдийн үзлэгт хамруулж ажилласан. Мөн цэргийн насны 150 залуучуудыг БЗДХ -ын урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж зөвлөгөө өгч ажилласан. 2024 онд шинээр хяналтад орсон 23 жирэмсэн эхийг 100% БЗХӨ/Дох/Тэмбүү илрүүлэх шинжилгээнд хамруулсан. Хяналтын хугацаанд БЗХӨ/ДОХ/Тэмбүүгийн шинжилгээ</p>
--	--	--	--	--	--	--	--	--	---

									хийж нэг жирэмсэн эмэгтэйг илрүүлж нөхрийн хамт эмчилсэн. Мөн сарын дараа дахин шинжилгээнд хамруулж ТИТР багасаж эмчлэгдэж эсэн мэнд амаржсан. Мөн 8-12 ангийн сурагчдыг В,С,вирус, шинжилгээнд хамруулж ажилласан. 9-12 ангийн сурагчдыг тэмбүүгийн шинжилгээнд хамруулж ХДХВ/ДОХ гэж юу вэ? Ямар замаар дамжин халдварлах, бэлгийн ариун цэвэр сахих, хүсээгүй жирэмслэлт зэрэг сэдвээр сургалт хийж гарын авлагаар ханган ажилласан.	
5	Нөхөн үржихүйн эрүүл мэндийг дэмжих чиглэлээр дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ. Үүнд: - Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээ	2021 2024	ЭМТ	270.сая	Эхийн эндэгдлийн түвшин 48 5 хүртэлх насны хүүхдийн, Нялхсын эндэгдлийн түвшин Өсвөр үеийн кабинетийг тоо-0 Сэтгэл зүйчийн тоо-0			НҮЭМ-ийн Тусламжийн хүрээнд явуулын амбулатори гурван баг болон 1,2,3 багт урьдчилан сэргийлэх үзлэгээр тус бүр 4 хүний бүрэлдэхүүнтэй 2-4 өдөр 15-49 насны 515 эмэгтэйг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан. Урьдчилан сэргийлэх үзлэгийг 71,5% тай.Эрхтэн тогтолцооны эмгэгтэй 91 эмэгтэйг эрүүлжүүлсэн. Эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн 75%,Эмийн эмчилгээ 35% тай.Өвчлөлөөр авч үзвэл Бөөрний үрэвсэл 45% Артерийн даралт ихсэлт 33% Хоол боловсруулах эмгэг 20% бусад эмгэг 2%-ийг эзэлж байна.Мөн 3 шатлалын нарийн мэргэжлийн эмч нар баг бүрдүүлэн эрт илрүүлгээр Есөнзүйл ЭМТ-д 2 хоног ажиллаж 15-49 насны 115 эмэгтэйг үзлэг шинжилгээнд хамруулж ажилласан. 15-49 насны 710 эмэгтэйгээс 450 эмэгтэй эмнэлгийн эмийн тендерт 929600 төгрөгийн 4 төрлийн	90	

									жирэмслэхээс хамгаалах эм тариагаар ханган ажиллаж байна.	
Зорилт 2. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг нэвтрүүлнэ.	2	Зооноз өвчин судлалын төв, сумдын болон өрхийн эрүүл мэндийн төвүүдийн лабораторийн болон оношилгооны багажийн чадавхыг дээшлүүлэн, эмчилгээ, сувилгааны нэр төрлийг нэмэгдүүлнэ.	2021 2024	ЭМТ	500.0 сая	ЗӨСТ лабораты шинжилгэ эний тоног төхөөрөм жийн хангалтын хувь-82 сумдын төвүүдийн лаборато			Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвар, томуу, томуу төст өвчин, зоонозын шалтгаант өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сургалт сурталчилгааны чиглэлээр нийт 17 ширхгийг сумын цахим орчин болон эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлж байгаа иргэдэд тараасан байна. Эрүүл мэндийн төв нь нийт 4 удаагийн халдварт болон зооноз өвчин судлалын сэдэвт сургалтыг эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилчдад халдварт өвчин хариуцсан эмч А.Дуламдорж зохион байгуулсан байна.	90
	3	Эрүүл мэндийн салбарт эмнэлзүйн олон улсын стандарт UpToDate систем, бүртгэл, хяналтын цахим тогтолцоог нэвтрүүлэн, эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангаж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	2021 2024	ЭМТ	500.0 сая	ЗӨСТ лаборато ын шинжилгэ ний тоног төхөөрөм жийн хангалтын хувь-82 сумдын төвүүдийн лаборато оношилго оны хувь-84			Нийт 2600 хүн амын бүртгэл, мэдээллийг жил бүр шинэчлэн хөтөлж, баяжилт хийж, эрүүл мэндийн 5 бүлгээр ангилан мэдээллийг тусламж, үйлчилгээний төлөвлөлт, зохион байгуулалтад ашигладаг. Бүртгэл, мэдээлэлтэй холбоотой ЭМС-ын 2019 оны А/611 тушаалын ӨЭ-1 анхан шатны бүртгэлийн маягыг хөтөлж ажиллаж байна. 2024 онд Эрүүл мэндийн төвийн 4 их эмч, 4 багийн эмч нар нь эмнэл зүйн олон улсын стандарт UpToDate систем, бүртгэл, хяналтын цахим тогтолцоог нэвтрүүлэн, эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангаж ажиллаж байна.	90
Зорилт 3. Цахим эрүүл мэнд, эрт илрүүлэг, эргэн дуудах	1	Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, сумдын Эрүүл мэндийн төвүүдэд мобайл	2021	ЭМТ	120.0 сая	Мобайл технологи йг нэвтрүүлс эн			Мобайл технологийг төхөөрөмжүүдийг бүрэн бүтэн байдлыг бэлдсэн эрүүл мэндийн төвийн эмч эмнэлгийн мэргэжилтэн	90

<p>тогтолцоог бүрдүүлж, яаралтай тусламжийн чанар, үйлчилгээг хөгжүүлнэ.</p>		<p>технологийг нэвтрүүлнэ.</p>				<p>байгууллагын тоо- 2</p>			<p>ажилчид алсын дуудлага болон яаралтай түргэн тусламжийн дуудлагад тогтмол ашиглаж хэвшээд байна.Зүрхний цахилгаан бичлэг болон мобайл эхо шинжилгээг нийт 2024 оны байдлаар 35 ард иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ цаг алдалгүй үзүүлээд байна. Эрүүл мэндийн төвийн яаралтай болон түргэн тусламжийн дуудлагад эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлдэг эмч, эмнэлгийн мэргэжилтэн ажилчид бүгд сургалтад сууж стандартын дагуу мобайл технологийг ажиллуулж мэдлэгээ нэмээд байна.</p>	
	2	<p>Оношилгоо, эмчилгээнд алсын зайн технологи ашиглан, цахим эрт илрүүлэг, эргэн дуудах тогтолцоог бүрдүүлнэ.</p>	2021 2022	ЭМТ	350.0	Оношилгоо			<p>Эрүүл мэндийн төв нь “Эрүүл мэндийн даатгалын сангаас үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмийн нэр, төрөл, үнийн дээд хязгаар, хөнгөлөлтийн хэмжээ”-ний шинэчилсэн жагсаалтын дагуу 549 худалдааны нэршлийн эм байдаг. Эрүүл мэндийн төв нь 2024 оны байдлаар давтан тоогоор 1764 цахим жороор бичиж олгосон байна. Мөн сэтгэц нөлөөт эмийн жорыг эмчийн хяналтад 2 удаа олгосон байна.</p>	90
	3	<p>Жирэмсний нэрийн хяналт, цэргийн үзлэг, эрүүл мэндийн хяналт, бэлгийн замын халдварт өвчний хяналтын программуудыг нэвтрүүлнэ.</p>	2021	ЭМТ	35.0 сая	Энэ төрлийн үйлчилгээнд цахим программ нэвтрүүлсэн тоо			<p>2022 оноос хойш жирэмсэн эмэгтэйчүүдийн бүртгэл мэдээллийг цахим программд оруулж 7 хоног бүр мэдээллийг шинэчлэн хянаж товлонд хугацаанаас хожимдож байгаа жирэмсэн эмэгтэй багийн эмч болон утсаар дуудан товлонд</p>	90

									<p>үзлэгт нь хамруулан ажиллаж байна.</p> <p>2024 онд нийт 23 жирэмсэн хяналтад орсноос хожуу хяналт 4 жирэмсэн эх орсон.</p> <p>ЭМС-ын 2024 оны 06 сарын 24 өдрийн А/292 тушаалын дагуу хяналтыг чанаржуулж, жирэмсний тээлтийн 20,28,32,36 долоо хоногтойд эрсдэлийн үнэлгээ хийж жирэмсний болон төрөлтийн хүндрэлээс сэргийлэн ажиллаж байна. Жирэмсний хяналтад хожуу орсон шалтгаанаар авч үзвэл 1 эх Улаанбаатар хотод 6 жил амьдарсан. 3 жирэмсэн эх жирэмслэхээс хамгаалах Ерөндөг, Суулгацтай байсан тул жирэмсэн болохгүй байх гэсэн шалтгаанаар хожуу хяналт бүртгэгдээд байна.</p>	
	4	Яаралтай тусламж үзүүлдэг нэгжийн тоог нэмэгдүүлнэ.	2021 2024	ЭМТ	330.0 сая	Яаралтай тусламж үзүүлдэг нэгжийн тоо-19			<p>Эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилчид яаралтай үед эмнэлгийн тусламжийг үзүүлэх чадварт 2024 онд дээд шатлал болон эрүүл мэндийн төвдөө давтан тоогоор 4-5 удаа хамрагдсан.мЭрүүл мэндийн төвийн яаралтай тусламжийн эм тариа болон багаж тоног төхөөрөмжийн хангалт 90-95% тай байна. Одоогоор яаралтайд тулгамдсан дутуу эм тариа байхгүй байна.</p>	90

	2	Эмнэлгийн эмчилгээний хоол, шим тэжээлийн мэргэжилтнийг бэлтгэнэ.	2021 2024	ЭМТ	70,0 сая	Эмчилгээний хоол, шим тэжээлийн мэргэжилтнийг тоо-0				2024 онд Эрүүл мэндийн төвийн тогооч Ц.Энхтуяаг Өвөрхангай аймагт эмчилгээний хоол судлалын чиглэлээр сургалтад 1 удаа хамрагдсан. Эрүүл мэндийн төвийн тогооч нь мэргэжлийн эмчилгээний хоолны тогооч болно.	90
Зорилт 4. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг бүрдүүлж, мэргэшүүлэн, чадавхыг нэмэгдүүлж, нийгмийн хамгааллыг дэмжинэ.	3	Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хангалт, сургалт хөгжил, нийгмийн баталгааг дэмжих хөтөлбөрийг үргэлжлүүлнэ.	2021 2022	ЭМТ	-	Нийгмийн Асуудалд Дэмжлэг Үзүүлсэн Мэргэжийн тоо – 5 Орон нутгийн урамшууллын багцад зарцуулсан мэргэжилтний тоо 83			2024 онд Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хангалт, сургалт хөгжил, нийгмийн баталгааг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Хөтөлбөрийн 1-р зорилт : Эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийн нийгмийн баталгааг сайжруулах хүрээнд: Ажлын байранд аюулгүй тав тухтай орчинд хэрэгцээт тоног төхөөрөмжөөр бүрэн ханган ажиллуулах, шаардлагатай нөхцөлд ашиглах хувцас хэрэгсэлээр ханган ажиллаа. Үүнд : Үйлчлүүлэгчдийн болон ажиллагсадын тав тухтай орчинг хангаж эмнэлгийн байрыг 100000000/ зуун сая/ төгрөгийн төсөвөөр засварласан. Мөн ажилчдад салбарын болон орон нутгаас зохион байгуулж спортын арга хэмээнд оролцоход зориулж 2380.000 төгрөгийн хувцасаар хангасан. Мөн Багийн эмчийг 578,000 төгрөгөөр компьютерээр хангасан. Дутагдалтай байсан сувилагчийн орон тоог хангах шаардлагын дагуу 1 сувилагчийг орон байраар ханган, цахилгааны хөнгөлөлт үзүүлэн ажиллуулж байна.	90	

									<p>2-р зорилт : Урамшууллын олон талт хэлбэрийг сонгож, хүртээмжийг бий болгох хүрээнд: Гүйцэтгэлийн санхүүжилтийн тогтолцоонд тулгуурлан ажил үүргийн дагуу үйлчилэх хүрээний хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг ур чадварын өндөр түвшинд хүргэн үйлчилж байгаа сувилагч, эмч, мэдээ мэдээллийг үнэн зөв хянаж ЭМД-д илгээдэг СТА-д гүйцэтгэлийн урамшууллыг 100 хүртэлх хувиар олгож эхлээд байна.</p> <p>4-р зорилт :Ес зүй хүн чанарыг эрхэмлэсэн хүний эрхийн мэдрэмжтэй баг хамт олныг бүрдүүлэх хүрээнд: Байгууллагадаа 5 хүний бүрэлдэхүүнтэй ёс зүйн багийг байгуулж, ажлын төлөвлөгөө гарган дотооддоо 4 удаа ёс зүйн сургалт зохион байгуулсан. 2024 онд эрүүл мэндийн ажилчдын ёс зүйтэй холбоотой өргөдөл гомдол албан ёсоор гараагүй.</p> <p>Эмнэлгийн эмч ажилчдын сурч боловсрох нөхцөлд анхаарч монголын мэргэжсэн нягтлан бодогч нарын сургалтанд 1 хүнийг хамруулж 350000, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын сургалтанд 1 хүнийг 100000, худалдан авах үйл ажиллагааны сургалтанд 3 хүнийг 255000, архив бичиг хэргийн сургалтанд 1 хүнийг 80000, халдвар хамгаалал эрүүл ахуйн сургалтанд 2 хүнийг 300000 төгрөгийг байгууллагын төсөвийн</p>
--	--	--	--	--	--	--	--	--	---

									зардлаас шийдвэрлэн ажиллаад байна.	
	4	Эрүүл мэндийн салбарын ажилтнуудын улирлын урамшуулал, ур чадварын нэмэгдлийг тэдгээрийн мэдлэг, ур чадвар, харилцаа, хандлага, ёс зүйн үнэлгээтэй уялдуулан олгодог тогтолцоонд шилжүүлнэ.	2021 2024	ЭМТ	1.4 тэрбум	Улирлын урамшуулал, ур чадварын нэмэгдүүлэх, үйлчилгээний менежментийг сайжруулсан байгууллагын тоо-0			Улирлын урамшуулал, үр дүнгийн мөнгийг ажлын үзүүлэлтийг удирдлагын багаар хэлэлцэн ажилтан бүрд үнэлгээ өгч олгож байна. 1-р улиралд үр дүн гүйцэтгэл 22 хүнд нийт-19255880 төгрөгийн урамшуулал 2-р улиралд 10 хүнд гүйцэтгэлийн урамшуулал мөн үр дүнгийн урамшуулал 22 хүнд 9289054 төгрөг 3-р улиралд үр дүн 23 хүнд 8491140 төгрөгийн урамшуулал олгосон. Мөн 2024 онд шинээр тэтгэвэр, тэтгэмж авах 2 эмч, мэргэжилтний мэдээллийн судалгааг дээд шатлад илгээсэн. Эрүүл мэндийн төвд ажил хавсарч гүйцэтгэж байгаа 4 хүнд үндсэн цалингийн 40 хувийн нэмэгдэл цалин олгож ажилласан.	90
Бүлгийн дүн									91,4%	
1.3. Биеийн тамир										
Зорилт 1. Хүн амын эрүүл мэндийг сайжруулах зорилгоор идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэн, гэр бүлийг дэмжиж, нийтийн биеийн тамирыг хөгжүүлнэ.	4	Сумдыг нийтийн биеийн тамирын арга зүйчтэй болгож, нийтийн биеийн тамирыг хөгжүүлнэ.	2020 - 2023	ЕБС	123.1	5 Арга зүйч			Сумын хэмжээнд 2023 онд нийтийн биеийн тамирын арга зүйчээр биеийн тамирын багш, дасгалжуулагч мэрэгжилтэй хүнийг хөдөлмөрийн гэрээ байгуулан ажилд авч нийтийн биеийн тамирыг хариуцуулан жилийн ажлын төлөвлөгөөг боловсруулан баталж биелэлтийг нь ханган ажиллаж байна. 2023 оны Сумын Засаг даргын Тамгын газрын санхүүгийн авудитаар орход суманд Биеийн тамирын арга зүйчийн орон тоо батлагдаагүй тул албан шаардлага авсан тул арга зүйчийг 2023 оны 11-р сараас чөлөөлөөд байна. Энэхүү салбарын хүрээнд “Эрүүл монгол	90

										<p>хүн” Үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлэх ажлын хүрээнд “Эрүүл чийрэг Өвөрхангайчууд” уриатай Ахмадын холбоотой хамтран “Эрүүл байхын үндэс, Эрүүл агаар хөдөлгөөн,” нэртэй аян 04 дүгээр сарын 01-с эхлэн өрнүүлсэн. Уг арга хэмжээ өргөжин албан байгууллагын алба хаагчид, Аж ахуй нэгж, ард иргэд, залуучууд нэгдэн боломжтой цаг хугацаандаа өглөө эртлэн босож сумын төвөөс баруун тийш ирж буцах 2-3 км газар алхалт, гүйлт хийж очсон газраа 20-25 минут идэвхтэй дасгал хөдөлгөөн, Бясалгал, Залбирал хийн хуваарийн дагуу үйл ажиллагаа зохион байгуулан оролцдог. Эрүүл мэндийн байдал, насны онцлогоос шалтгаалан тэгш хэмтэй газар, уул, өндөрлөг газар явах алхалтын зай янз бүр байдаг. Тус аянд өглөөдөө 30-40 хүн оролцон эрүүл агаарт нийтийн биеийн тамирын идэвхитэй дасгал хөдөлгөөн хийн өөрсдийгөө эрүүлжүүлэн чийрэгжүүлж эрүүл мэнддээ үнэтэй хувь нэмэр оруулж байна. “Хөдөлгөөн, эрүүл цаг” Сургуулийн өмнөх насны хүүхдийн цээж, гэдэс, нуруу, хөлийн булчинг хөгжүүлэх дасгал, үндсэн хөдөлгөөнүүд, тэнцвэрийг сайжруулах дасгалыг “хөдөлгөөн-эрүүл мэнд” цагаар өдөр бүр 2-5 насны хүүхдүүдийн дунд бие бялдрын онцлог, насны ангилалаас нь хамааран тоглоомон хэлбэрээр, дууриан хийх аргаар өглөөний дасгал 08:00-08:30 минутын</p>
--	--	--	--	--	--	--	--	--	--	---

										<p>хооронд бие бялдрын хөгжилийг сайжруулах зорилгоор цэвэр агаартай өрөөнд хийлгэж хэвшсэн байна. Нэг хөдөлгөөнийг 5-6 удаа давтан хөгжилтэй, хөгжөөнтэй, инээдтэй арга барилаар дасгал хөдөлгөөн хүүхдүүд хийдэг. Цаг агаар сайхан тогтуун үед аль болох гадаа агаар салхинд бөмбөгөөр тоглох, цагираг эргүүлэх, гулсуур дээр гулгах, нуугдаж тоглох зэрэг хүүхдийн идэвхтэй хөдөлгөөнийг дэмжин ажилладаг. “МАРТЫН-8” Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах олон улсын өдөр Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Эмэгтэйчүүдийн зөвлөл, Эмэгтэй төлөөлөгчид, Ахмадын хороо, Соёлын төв хамтран 2024 оны 03 дугаар сарын 09-ны өдрийн 10 цагт сумын Ерөнхий боловсролын сургуулийн спорт зааланд бүх эмэгтэйчүүдийн дунд нас харгалзахгүй сугалаагаар баг бүрдүүлж Волейболын тэмцээн, Дартсны тэмцээн (зөвхөн 45-аас дээш насны) эмэгтэйчүүдийн дунд, мөн орой нь Азын сугалаатай цэнгээнт бүжиг 19 цагаас соёлын төвд нийт бүсгүйчүүдийн хүрээнд арга хэмжээг зохион байгуулж ажилласан. Уг арга хэмжээнд Волейболлын төрөлд 8 багийн 64 тамирчид, Дартсын төрөлд 35 тамирчид оролцон давхардсан тоогоор 112 эмэгтэйчүүд тус үйл ажиллагаанд хамрагдсан байна.</p> <p>“Чөлөөт бөх” Монгол Улсад Биеийн тамир спортын салбар үүсч хөгжсөний 100</p>
--	--	--	--	--	--	--	--	--	--	---

									жилийн ойн хүрээнд зохион байгуулж буй “Чөлөө бөхийн өсвөр үе”-ийн 2024 оны аймгийн аварга шалгаруулах тэмцээнд Есөнзүйл сумын Есөн-өлзий дэвжээний 11 тамирчидаас 2 мөнгө, 4 хүрэл медалл хүртэн амжилтай оролцсон. Хүүхдүүдийн хөгжил оролцоог дэмжиж сургуулийн захиргаа, Засаг даргын тамгын газар нь дэмжлэг туслалцаа үзүүлэн хамтран ажилласан.	
	5	Биеийн тамирын зориулалтын зам, гадна талбай болон хүүхэд, залуучуудын спорт цогцолбор бий болгож, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийг нэмэгдүүлэн, нийтийн биеийн тамирын орчныг бүрдүүлнэ.	2021 - 2024	ЕБС	2.0 тэрбум	5			440 хүүхдийн суудалтай хуучин сургуулийн гадна талбайд байсан биеийн тамирын хэрэгслүүд /турник, тэмээн шат, савлуур/-ийг авчирч шинэ сургуулийн гадна талбайд байрлуулсан бөгөөд байгууллагын төсвийн хөрөнгөөр шинээр сагсан бөмбөгийн нэг шийдийг нэмж байрлуулахын сацуу нэмж турник, шат байрлуулахаар бэлдэцийг авсан байна. Мөн хөлбөмбөгийн талбайгийн талбайг байгуулахаар газрын асуудлыг шийдвэрлэж гэрчилгээг гаргуулан авах ажлыг зохион байгуулсан.	70
Зорилт 2. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд мэргэжлийн спортыг дэмжиж, тамирчдын тив, дэлхий, олимпийн түвшинд өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлнэ.	1	Өсвөрийн шигшээ багийг жүдо бөх, чөлөөт бөх, шатар, таеквондо, хүндийн өргөлт, хөнгөн атлетик, цана, волейбол, сагсан бөмбөг, теннисний спортын төрлүүдээр байгуулж, Хайрхандулаан сумын ерөнхий боловсролын сургуульд болон шаардлагатай спортын	2021 - 2024	ЕБС	65.3 сая	- Шигшээ багийн төрөл			Тус сургуульд үндэсний бөхийн болон чөлөөт, жүдо бөхийн секцийг биеийн тамирын багш нар хичээлүүлдэг бөгөөд бүс, аймгийн чанартай уралдаан тэмцээнүүдэд амжилттай оролцож медаль сурагчдын тоо жилээс жилд нэмэгдэж байна. Биеийн тамир багш М.Уламбаяр, О.Түмэннаст нарын бэлтгэсэн сурагчид Монгол Улсад "Биеийн тамир спортын салбар үүсч хөгжсөний 100 жилийн ойн хүрээнд зохион байгуулж буй	100

		чиглэлүүдийн дасгалжуулагчийг орон тоогоор ажиллуулна.								Чөлөөт бөхийн өсвөр үеийн 2024 оны аймгийн аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцож 10а ангийн сурагч Б.Нямсүрэн Мөнгөн медаль, 9а ангийн сурагч Я.Нямдорж мөнгөн медаль 8а ангийн сурагч Доржзовд хүрэл медаль 8а ангийн сурагч А.Пагамсүрэн хүрэл медаль 9а ангийн сурагч Б. Даваажав хүрэл медаль 9а ангийн сурагч Д. Эрхэмбаяр хүрэл медаль хүртлээ. Мөн 10 дугаар ангийн сурагч Б.Нямсүрэн нь Улсын аварга шалгаруулах чөлөөт бөхийн тэмцээнд амжилттай оролцлоо.	
Бүлгийн дүн										86,6%	
1.4. Боловсрол											
Зорилт 1. Багш, сурагчдын сурч, хөгжих орчныг сайжруулж, сургалтын чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.	6	Шаардлагатай сумдын сургуулиудад спорт тоглоом, хөл бөмбөгийн талбай шинээр барина.	2022 - 2024	ЕБС		-	3			Хөл бөмбөгийн талбай бариулах газрын асуудлыг шийдвэрлүүлсэн бөгөөд гэрчилгээ авсан.	50
	7	Зарим сумдын сургууль, цэцэрлэгт хөргүүр бүхий мах, ногооны зориулалтын зоорь, агуулах барих, сургууль, цэцэрлэг орчмын эзэмшлийн талбайн тохижилт, авто машины зогсоол бий болгоно.	2021 - 2024	ЕБС		92.0 сая	4			Тус сумын Ерөнхий боловсролын сургуульд зоорь агуулах баригдаагүй болно. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагаад 2023 оны орон нутгийн хөгжлийн сангаар 40т контейнерыг агуулахын зориулалтаар тохижуулан хүлээн авч үйл ажиллагаандаа ашиглан ажиллаж байна.	50
Зорилт Ерөнхий боловсролын	2. 3	Арвайхээр, Хархорин, Богд, Нарийнтээл, Өлзийт, Төгрөг, Бүрд,	2021 - 2024	ЕБС		152,8 сая	2			2021 онд байгууллагын нийт анги танхим, нийтийн эзэмшлийн талбайн халаалтын шугамыг сольж	100

сургууль, цэцэрлэг, дотуур байрны сургалтын болон үйлчилгээний орчин нөхцөлийг сайжруулж, ажиллана.		Хужирт, Есөнзүйл сумдын цэцэрлэгт их засвар, Хужирт сумын 2 дугаар цэцэрлэгт сантехникийн засвар хийнэ.							шинэчилсэн. Энэ нь багш, ажилтанууд болон цэцэрлэгт хамрагдаж байгаа хүүхдүүдийн сурч хөгжих таатай орчин нөхцөлийг бүрдүүлсэн үр дүнтэй ажил болсон.	
	4	Төгрөг, Сант, Бат-Өлзий, Өлзийт, Есөнзүйл сумдын Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байруудад их засвар хийнэ.	2021 - 2024	ЕБС		112,8 сая	2 дотуур байр		2022 оны аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсанаар нийт 50 сая төгрөгний өртөгөөр тус сургуулийн 80 хүүхдийн хүчин чадалтай дотуур байранд 41 цонх, 13 хаалгыг сольж цонх, хаалганы амлагааг Өвөрхангай аймгийн Од ХХК хийж гүйцэтгэсэн. Мөн 2023 онд 07-08 сард нийт 63 сая төгрөгний өртөгөөр тус сургуулийн 80 хүүхдийн хүчин чадалтай дотуур байрны доод давхарын тасгуудын хаалга, хана, тааз 100% хусалттай засварыг Галбын тос ХХК хийж гүйцэтгэсэн.	100
	5	Сургууль, цэцэрлэгийн орчны эрсдэлийн үнэлгээг улирал бүр хийж, стандартад нийцүүлэх арга хэмжээг зохион байгуулна.	2021 - 2024	ЕБС		200	20 хувь		Цэцэрлэгийн эрхлэгчийн тушаалаар Гамшигаас хамгаалах зөвлөл байгуулан эрсдэлийг бууруулах төлөвлөгөө боловсруулан ажлуудыг үе шаттай зохион байгуулан Аймгийн Онцгой байдлын газраас зөвлөгөө чиглэл авч ажиллаж байна. Эрсдэлтэй гарсан тог цахилгааны утас, ил задгай нүх, тоглоомын эвдрэл гэмтэл хүүхдэд аюул үүсгэхүйц хэсэг, цэвэрлэгээ үйлчилгээний чанар зэрэгт тухай бүр нь засвар үйлчилгээ хийхээс гадна эрсдэлийн шалтгаан нөхцөлийг олж дахиж үүсгэхгүй	100

										байх ажлуудыг зохион байгуулсан. Ерөнхий боловсролын сургуулийн Захирлын тушаалаар баталсан ажлын хэсэг дотуур байр болон сургуулийн орчны эрсдлийн үнэлгээг хийсэн бөгөөд үнэлгээний дагуу хийх ажлын төлөвлөгөөг гарган төлөвлөгөөний дагуу орчны эрсдэлийг бууруулах зорилгоор гэрэл цахилгааны монтаж засах, нэмэлт гэрлүүд байрлуулах, хаалганы цоож цуургыг засах, сэлбэх, тавилга эд хогшлыг засах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Мөн аймгийн БШУГ, Цагдаагийн газраас зохион байгуулж буй нөлөөлийн аяны хүрээнд байгууллагын тодорхой бүсүүдэд эрсдлийн үнэлгээг хийсэн. Өөрийн байгууллагын эрсдэлийн ерөнхий үнэлгээг Өвөрхангай аймгийн Онцгой байдлын газарын мэргэжилтэнүүдийн сургалт зөвлөгөөний дагуу хийж холбогдох газраар хянуулж ажилласан. Үнэлгээгээр “Дунд” эрсдэлтэй гэж үнэлэгдэн цаашид засан сайжруулах ажлуудаа төлөвлөн хийж хэрэгжүүлсэн ажлын тайлангаа Өвөрхангай аймгийн онцгой байдлын газарт хүргүүлж ажиллалаа.	
Зорилт 3. Боловсролын байгууллагуудад шаардлагатай хөрөнгө оруулалтыг үе шаттайгаар хийж, багш, сурагчдын	1	Ерөнхий боловсролын сургуулиудыг шаардлагатай кабинет, лаборатори, цахим тоног төхөөрөмжөөр хангана.	2021 - 2024	ЕБС		98.7 сая	-	7 сая	7 сая	Аймгийн засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсанаар 2021 оны 02 сард 16197750 төгрөгний үнэ бүхий химийн лаборатори, 2022 онд нийт 64180,0 төгрөгний англи хэлний лингафоны танхимын техник хэрэгсэл, ширээ сандалууд, нийт 6801,0 төгрөгний физикийн	90

сурч, хөгжих орчныг сайжруулж, боловсролын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.									лабораторийн туршилт, сургалтын хэрэглэгдэхүүнийг татан авчир хичээл сургалтандаа ашиглаж байна. 2021 оны 02 дугаар сард 16 сая төгрөгний үнэ бүхий химийн лабораторийн иж бүрдлийг татан авчирч кабинетад байршуулан хичээл сургалтандаа ашиглаж байна. 2024 онд Физик болон Монгол хэл бичгийн ангид 75 инчийн зурагтийг байршуулсан		
	2	Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг шүүлтүүртэй ундны цэвэр усаар хангах, хатуу зөөлөн эдлэлийг шинэчлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.	2021 - 2024	ЕБС			6 ширхэг	26,66 1,0	26,66 1,0	2021 онд тус сургуульд нийт 2666100 төгрөгний 6ш баллонтой ус цэвэршүүлэгч авчирч 120 хүүхдийн суудалтай хичээлийн байранд 1, 320 хүүхдийн хичээлийн байранд 4, дотуур байранд цэвэршүүлэгчийг байршуулаа өдөр бүр баллоныг худгаас ус авч дүүргэж багш, сурагч, ажилчдыг халуун ус уух нөхцөл боломжийг хангажн ажиллаж байна.	100
	7	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт тэгш хамрагдах боломжийг бүрдүүлэн, хамран сургалтыг нэмэгдүүлэх, шаардлагатай тохируулгат хэрэглэгдэхүүнээр хангаж, багшлах боловсон хүчнийг давтан сургах, мэргэшүүлэх, жирийн ангид шилжин суралцах чадварыг дээшлүүлэн, сэргээн	2021 - 2022	ЕБС		31.9 сая	85 хувь		.	2021 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр аймгийн ГБХЗГ, БОЭТ, БСУГ-ын хамтарсан баг хүүхэд хамгаалал болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурах нөхцөл боломж, эрүүл мэнд, эцэг эх, асран хамгаалагч нарт сургалт мэдээлэл хийх ажлаар тус сургуульд ажиллаж 5 сурагчийг БОЭТ-ийн нарийн мэргэжлийн эмч нарт үзүүлэх хүсэлт гаргасны дагуу 2022 онд сумын эрүүл мэндийн төвийн эмч нар тус сурагчдыг үлзэг шинжилгээнд хамруулснаар 2 сурагчийг ХБ гэж магадласан. 2024-2025 оны хичээлийн жилд тус сургуульд нийт 5 хөгжлийн	100

		засах үйлчилгээг нийгэм, хамт олонд нь түшиглэн тогтмол үзүүлнэ.							бэрхшээлтэй сурагч суралцаж байгаа бөгөөд 1 сурагч нь ганцаарчилсан сургалтын хөтөлбөрөөр хичээллэж байна.		
Зорилт 4. Сургууль бүрт үйлчилгээний стандартын шаардлага хангасан хоол үйлдвэрлэлийн байр, тоног төхөөрөмж, хүний нөөцийг бүрдүүлж, бүх сурагчдыг үдийн хоолны хөтөлбөрт хамруулна.	1	.Ерөнхий боловсролын сургуулийн “Үдийн цай” арга хэмжээг “Үдийн хоол” болгох арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлнэ.	2021 - 2024	ЕБС		1 тэрбум 220 сая	31	390,37 4,0	390,37 4,0	2021-2022, 2022-2023, 2024-2025 оны хичээлийн жилд бага ангийн нийт 198 сурагчдад бага сургуулийн гал тогоогоор дамжуулан үдийн хоолоор бүрэн үйлчилж байгаа бөгөөд хоолны цэсийг бага ангийн сургалтын менежер, нярав, тогооч нар хамтран 14 хоног тутамд сольж цэсийн дагуу халуун хоол ундаар үйлчилж байна.	100
	2	Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын гал тогоог стандартын шаардлагад нийцүүлэх, засварлах, зориулалтын хөргүүрийн тоног төхөөрөмжөөр хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, хоол зүйч, хоол үйлдвэрлэлийн технологич орон тоогоор ажиллуулна.	2021 - 2024	ЕБС	53.7 сая	-		12,85 0,0	12,85 0,0	320 хүүхдийн суудалтай шинэ хичээлийн байрны гал тогоонд нийт 12850000 төгрөгний үнэ бүхий 10ш гал тогооны тоног төхөөрөмж татан авчирч суурилуулсан.	100
	2	Таваас доошгүй хичээл судлагдахуунаар анги нийтийн аймгийн олимпиад уралдаан зохион байгуулж, анги хамт олны амжилтыг үнэлж, дүгнэнэ.	2021 - 2024	ЕБС		-	5				Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газраас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг анги нийтийн олимпиад нь нийт 4 төрлөөр /математик, монгол хэл, түүх, гадаад хэл/ ковидын улмаас зохион байгуулагдаагүй байсан бөгөөд 2022 оны 10 сар, 2023 оны 04 сар, 2024 оны 4 сард дахин аймгийн хэмжээнд зохион байгуулагдсан. Тус олимпиадад 36 анги, 8а ангиуд математикийн

									хичээлээр гутгаар зэргийн болзол хангасан.	
	8	Ерөнхий боловсролын сургалтын чанарын үндэсний үнэлгээнд жил бүр амжилтаа ахиулан, сургуулиудыг олон улсын PISA үнэлгээнд хамруулж, улсын дундажаас дээгүүр үнэлэгдэх зорилт тавин ажиллана.	2021 - 2022	ЕБС		20	-		2022 оны 05 дугаар сард зохион байгуулагдсан сургуулийн болон багшийн гүйцэтгэлийн үнэлгээнд тус сургуулийн бүх багш нар болон түүврээр сонгогдсон сурагчид шалгалдсан бөгөөд тус сургуулийн үнэлгээ нь улсын дундажаас доогуур, аймгийн дундажаас дээгүүр шалгагдсан бөгөөд 2023 оны 5 сард зохион байгуулагдсан сургуулийн болон багшийн гүйцэтгэлийн үнэлгээнд нийт 21 багш хамрагдсанаас 5 багш урамшуулал авах болзол хангаж сургуулийн үнэлгээ өмнөх оныхоос ахисан. 2024 онд зохион байгуулагдсан сургуулийн болон багшийн гүйцэтгэлийн үнэлгээгээр нийт 19 багш хамрагдсан бөгөөд 3 багш урамшуулал авах болзолыг хангасан. Олон улсын PISA үнэлгээнд тус сургууль нь хамрагдаагүй болно.	100
Зорилт 6. Сургалтын хөтөлбөр, агуулга, арга зүйд монголын түүх, хэл, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч сэтгэлгээ, хувь хүний хөгжил, төлөвшил, хос бичигтэн болох зэрэг хүн төрөлхтний	3	Сургуулийн хүүхдийн өөрийн удирдлагын байгууллагын санал санаачлагыг дэмжиж хүүхдийн авьяас чадварыг хөгжүүлэх, бие даан бүтээлчээр суралцахуйд суралцах боломжийг нээн, сургуулийн харьяа уламжлалт өв соёл, хэл, сэтгэн бодох, техник технологи, оюуны спортын төрлийн клуб, төв,	2021 - 2024	ЕБС		-	клуб, төв, дугуйлан, секцэд хичээл лэх сурагчдын тоог нэмэгдүүлнэ.	Дугуйлан секц болон хүүхдийн өөрөө удирдах байгууллагуудад нэмэлт элсэлтээ авч үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу ажлуудыг зохион байгуулсан. Тус сургуульд үндэсний бөх, чөлөөт болон жудо, бамбо бөх, үндэсний болон орчин үеийн хөгжмийн клуб, эко клуб, эмч клуб, өсвөрийн улаан загалмай клуб, илтгэх урлагийн клуб, урлан клуб, ангийн дарга нарын клуб, сэтгэх чадварын клуб, Урлан-санхүүч клуб зэрэг хүүхдийн өөрөө удирдах байгууллага, дугуйлан секцүүд үйл ажиллагаа	90	

нийтлэг үнэт зүйлийг тусган хэрэгжүүлнэ.	дугуйлан, секцэд хичээллэх сурагчдын тоог нэмэгдүүлнэ.								зохион байгуулж байгаа бөгөөд тус клубүүдэд нийт сурагчдын 85% нь хамрагдаж байна.
--	--	--	--	--	--	--	--	--	--

Зорилт Багшлах боловсон хүчний мэргэжил арга зүйн хөгжлийг дэмжиж, тэднийг урамшуулах, харилцан туршлага солилцох боломжийг олгож, нийгмийн асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ.	8.	1	Салбарын албан хаагчдын нийгмийн хамгааллыг сайжруулах, тэдний эрүүл мэнд хөдөлмөрийн үнэлэмж, орон байрны нөхцлийг сайжруулах асуудлуудыг үе шаттайгаар шийдвэрлэнэ.	2021 - 2024	ЕБС		31.0 сая	-	1,4 сая	1,4 сая	2022 оны 10 дугаар сард бүх багш ажилтныг нэмэлт эрүүл мэндийн багц үзлэгүүдэд үзүүлэхээр Өвөрхангай аймгийн Хархорин сумын эрүүл мэндийн төвтэй гэрээ байгуулсан. Бага ангийн багш болон тогооч нарыг аймгийн БЭОТ-тэй хамтран үзлэг шинжилгээнд хамруулсан. Тус сургуулийн мэргэжлийн багшийн хангалт 92,5%-тай бөгөөд математик-мэдээлэлзүйн багш, орос-англи хэлний багшийн дутагдалтай байна. Дутагдалтай багшийн судалгааг жилд 2 удаа гарган холбогдох газруудад хүргүүлдэг бөгөөд аймгийн БШУГ-ын мэргэжилтнүүдтэй зөвшилцсөний үндсэн дээр мэргэжлийн багш нарыг авч ажиллуулж хэвшсэн. Жирэмсэний болон амаржсаны амралттай багш, ажилчдын оронд түр ажлын байр зарлан багш, ажилтныг авч ажиллуулж байна. Мөн Орос-Англи хэлний багш болон Газар зүйн багш нарыг сумын Төрийн албан хаагчдийн орон сууцанд оруулсан. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хувьд 2024 оны 8 дугаар сард бүх багш ажилтныг урьдчилан сэргийлэх үзлэгүүдэд БОЭТ гэрээ байгуулан 100% хамруулсан.2024 оны хичээлийн жилд дутагдалтай байсан бүлгийн багш 1, Эрхлэгч 1 Аймгийн боловсролын газар зохиох журмын дагуу зохион байгуулан ажлын байрыг нөхөж 100% мэргэжлийн багш ажилтан ажиллаж байгаа бол БШУГ-аас шинээр 2024	90
---	----	---	---	-------------------	-----	--	----------	---	------------	------------	--	----

									оны 09 дүгээр сарын 1-нээс хэрэгжихээр батлагдсан нормативыг хэрэгжүүлэхтэй холбоотой Аргазүйч, Үйлчлэгчийн орон тоог Аймгийн Боловсролын газраар батлуулан 11 дүгээр сарын 01-ний өдрөөс үйлчлэгчийн ажлын байранд ажилтан сонгон шалгаруулан ажиллуулж байгаа, Аргазүйчээр ажиллах мэргэжил арга зүйн шаардлага хангасан аргазүйчээр ажиллах сонирхолтой хүн бүртгэгдээгүй учир тус ажлын байранд ажиллах ажилтанг одоогоор аваагүй байна. Жирэмсний болон амаржсаны амралттай багш, ажилчдын оронд түр ажлын байр зарлан багш, ажилтныг авч ажиллуулж байна. БШУЯ Аймгийн боловсролын газраас багш нарын компьютержуулах ажлын хүрээн 4 багш компьютержуулсан. Шинээр ирсэн багшийг орон нутгийн зүгээс орон байраар хангасан	
2	Багш, удирдах ажилтны мэргэжил боловсролыг дээшлүүлэх "Багшийн цахим кампус" зайн сургалтын системийг хөгжүүлж, багш нарын 70-аас доошгүй хувийг зайн сургалтаар мэргэжил, боловсролыг нь дээшлүүлнэ.	2021 - 2024	ЕБС		-	70 хувь		Өвөрхангай аймгийн БСУГ-аас өвөрхангайн багш нарын цахим кампусаар дамжуулан мэргэжлийн багш нарын дунд зохион байгуулсан онлайн "Хамтдаа суралцъя" сургалтад тус сургуулийн 28 багш, удирдах ажилтнууд амжилттай хамрагдаж 6 чиглэлээр мэргэжил боловсролоо дээшлүүлж, дадлага, дасгал ажлуудыг хийж гүйцэтгэсэн бөгөөд сургалтын шалгалтын гүйцэтгэлийн хувиар 92,7%-тай амжилттай шалгагдлаа. Өвөрхангай аймгийн багш нарын "Багшийн цахим	100	

									<p>кампус”, мэргэжлийн багш нарын бүлэг, групп, Arplus цахим сургалтын байгууллага болон БМДИ, БҮТ-үүдээс зохион байгуулсан хуваарьт болон хуваарьт бус сураглтуудад багш нар амжилттай хамрагдан сорил даалгаврыг гүйцэтгэн мэргэжил боловсролоо дээшлүүлэхийн сацуу заах арга, ур чадвараа түгээн дэлгэрүүлж цахим хичээлүүдийг боловсруулан багшийн цахим кампуст байршуулсан. Мөн бага ангийн математик, 8 дугаар ангийн физик, 11 дүгээр ангийн түүх, 7 дугаар ангийн түүхийн хичээлүүдээр нэгж хичээл боловсруулах medle.mn сайтад байршуулсан. Тус сургуулийн мэргэжлийн багш нар нь багшийн цахим кампус болон Өвөрхангай аймгийн багшийн цахим кампусаар дамжуулан мэргэжил боловсролоо дээшлүүлэх цахим сургалтуудад шат дараатай хамрагдсан бөгөөд “Хамтдаа хөгжье-харилцан суралцъя” аяны хүрээнд зхион байгуулсан онлайн сургалтад бүх мэргэжлийн багш нар хамрагдаж 98,7%-тай үнэлэгдсэн. Мөн 2022 оны 12-2023-01 сар дуусталх хугацаанд тус сургуулийн 30 багш, удирдах ажилтнууд 3600000 төгрөгний сургалтад хамрагдахын сацуу “Алсын хараа-2050” хөгжлийн бодлогын сургалтад нийт 14 багш хамрагдаж батламж сертификатаа авсан. 2024 онд 29 багш сургалтад хамрагдаж сертификатаа авсан. Өвөрхангай аймгийн БСУГ-аас</p>
--	--	--	--	--	--	--	--	--	---

										<p>өвөрхангайн тогооч нарыг чадвахжуулах сургалтад тогооч хамрагсан. Өвөрхангай аймгийн багш нарын “Багшийн цахим кампус”, мэргэжлийн багш нарын бүлэг, групп, Arlus цахим сургалтын байгууллага болон БМДИ, БҮТ-үүдээс зохион байгуулсан сонголтод сураглтуудад багш нар амжилттай хамрагдан сорил даалгаврыг гүйцэтгэн мэргэжил боловсролоо дээшлүүлэн сертификадаа авсан. Багшийн гүйцэтгэлийн үнэлгээний сургалтад 3 удаа 2 багш, Хүүхэд хамгааллын тухай хуулийн сургалт, байгууллага болон багшийн гүйцэтгэлийн үнэлгээний сургалтад эрхлэгч хамрагдсан бол хүүхдийн хөгжлийн үнэлгээ сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх зохион байгуулах тухай, багшийн хөтөлбөр төлөвлөгөө боловсруулах аргазүйн сургалтад бүлгийн 1 багш тус тус хамрагдсан байна.</p>
--	--	--	--	--	--	--	--	--	--	---

Зорилт 9. Хүн бүрт чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ.	1	Цахим сургалтын нэгдсэн платформ бий болгон хүн бүр орон зай, цаг хугацаанаас үл хамааран өөрийн хүссэн чиглэлээр насан туршдаа суралцах боломжийг бүрдүүлнэ.	2021 - 2022	ЕБС		10.0 сая	-	3,6 сая	3,6 сая	Тус сургуулийн мэргэжлийн багш, удирдах ажилтнууд Aplus.mn цахим платформоор дамжуулан 3 төрлийн сургалтад хамрагдахаар бүртгүүлсэн бөгөөд сургалт 10 дугаар сарын 24-нөөс эхэлж 12 дугаар сард дуусч батламжаа гардан авсан. Сургуулийн өмнөх боловсролын байгууллага нь Цахим шилжилтийн жилийн ажлын хүрээнд интэрнэтэд холбогдох ажлыг зохион байгуулсан. Багш нарын дата багц ашиглах ажлыг юнител, скайтел компаниудтай холбогдон шууд гэрээ хийсэн. Багш ажилтан бүр цахим орчинд ажиллах, суралцах, өөрсдийн өдөр тутмын ажилдаа ашиглах боломж нөхцөлөөр 100% хангаж ажилласан.	70
	2	Насан туршийн боловсрол олгох сургалтыг бизнес, амьдрах ухаан, хүний хөгжил, ёс суртахуун, гоо зүй, гэр бүл, байгаль орчны, иргэний боловсрол (эрх зүй, эрүүл мэнд, гамшгаас хамгаалах) олгох чиглэлээр сургалтын олон талт хэлбэрээр зохион байгуулна.		ЕБС		-	18 хувь			2022 онд 8 төрлийн 27 удаагийн давтамжит сургалт үйл ажиллагаагаар нийт 380 хүүхэд, иргэнд хүрсэн. Цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан 320 иргэнд танхимаар, 60 иргэнд онлайн буюу зайнаас хүргэсэн. Дээрх чиглэлийн сургалтаас санхүүгын болон угийн бичиг, мэргэжил сонголт, хувь хүний хөгжил гэх сургалт нь олныг хамарсан сургалт болсон бөгөөд өөрийн зүгээс урамшуулсан. 2024 онд эцэг эхийн нийтийн хурлыг 2 удаа амжилттай зохион байгуулсан бөгөөд Физикийн хичээлийг сонгон судалж байгаа сурагчид эцэг эхчүүддээ туршилтын үзүүлэх сургалтыг зохион байгуулсан.	70
	3	Насанд хүрэгчдийн тасралтгүй сургалт	2021	ЕБС		-	-			-Насанд хүрэгчид буюу бичиг үсгийн боловсрол олгох нийт 16	70

		болон ерөнхий боловсрол нөхөн олгох сургалтыг зохион байгуулна.							суралцагчидад хоёр удаагийн давтамжтай зайны сургалт явуулах, түүнд шаардлагатай далгаварын санг мөн хоёр удаа явуулахад шаардлагатай 128000 төгрөгийг сум орон нутгийн удирдлага, багын дарга нарын тусламжтай зохион байгуулсан. Үүнээс дүйцсэн хөтөлбөрийн системд бүртгэлтэй хоёр сурагчийг ерөнхий боловсролын сургуулийн хамт олны тусламжтай анги дэвшүүлсэн. Угийн бичгийн гурван үндсэн чиглэл болох –төлөвлөгөө боловсруулах үйл ажиллагааны чиглэл, угийн бичиг хөтлөх уяалдаа холбоог сайжируулах, өрх бүрээр хөтлүүлэх бодлогын үйл ажилгаа, угийн бичгийн ойлголтыг сурагчидад хүргэх гэсэн чиглэлийн дагуу төлөвлөгөө, ажлын хэсэг байгуулж төрийн албан хаагчид, иргэд гэсэн чиглэлийн үйл ажиллагааг хүргэн ажиллалаа.	
4	Монгол бичигт суралцах бүх нийтийн хөдөлгөөн өрнүүлнэ.	2021 - 2024	ЕБС		40.0 сая	2		Монгол бичгийн танхимд хичээл сургалтын үйл ажиллагааг амжилттай зохион байгуулж байгаа бөгөөд сургалтын хэрэглэгдэхүүнийг баяжуулан сурагчдын суралцах таатай орчинг бүрдүүлэн ажиллаж байна. “Зүйр цэцэн үгс” А4 үзүүлэнг 40 ш, “Монголбичгийн үсгийн карт” 140ш үзүүлэнг үндэсний бичгээр хэвлэн сургалтад ашиглаж байна. Мөн ханын үзүүлэнг сурагчдад хүртээмжтэй байдлаар хөдөлгөөнт маягаар байршуулан ашиглаж байна. Нийт 110 ТАХ-ыг Монгол бичгийн уншлагын ном, Хичээнгүй	100	

										<p>бичгийн номоор ханган бие даан сурах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна. Улс орон даяар зохион байгуулсан Төрийн албан хаагчдын “Монгол бичгийн түвшин тогтоох” судалгаанд бүрэн хамруулан ажилласан. 2025 онд албан бичгийг хос бичгээр хөтлөх болсонтой холбоотойгоор бэлтгэл ажлыг хангахын тулд төрийн албан хаагчдыг анхан, дунд шатны сургалтад хамруулахаар төлөвлөн ажиллаж байна. “Монгол бичиг үндэсний хөтөлбөр-3”-ыг сурталчилан цахим хэлбэрээр бэлтгэн ажилласан. Цар тахалтай холбоотойгоор танхимын сургалт явуулах боломжгүй тул “Монгол бичгээ дээдлэгч сум” уриан дор монгол бичгийн цахим хичээлийг группэд байршуулсан. ТАХ-д группэд тавьсан хичээлийг үзэх хандлага маш муу байгаад Албан байгууллагын дарга нар анхаарч үр дүнг тооцон ажиллах шаардлагатай байна. Мөн иргэдийн хүсэлтийг харгалзан сургалт зохион байгуулахаар төлөвлөсөн хэдий ч цар тахлаас шалтгаалан хэрэгжсэнгүй. Бичиг соёлын хишиг өдрийг тэмдэглэн “Үндэсний бичиг”-ийг сурталчилан, олон нийт, сурагчдын идэвхийг өрнүүлж төрөл бүрийн уралдаан зохион байгуулан ажилласан. Монгол бичгийг олон нийтэд сурталчилан таниулах уралдаан тэмцээн зохион байгуулах ажлын хүрээнд Иргэд, ААН, Албан байгууллагынхны дунд “Үндэсний</p>
--	--	--	--	--	--	--	--	--	--	--

										<p>бичгээ сурах үйлсэд бид ...” илтгэлийн уралдаан “Цахим орчинд үндэсний бичгээрээ бичигчээ” аян өрнүүлэн мөн Уран бичлэг, Хурдан уншигч, Алдаагүй бичигтэн уралдааны удирдамжийг бүх Албан байгууллагад хүргэн ажилласан. Тус сургуулийн монгол хэл, уран зохиолын багш нар бүх албан байгууллагуудын төрийн албан хаагчдад монгол бичгийн анхан болон дунд шатны сургалтыг 2022 оны 10 дугаар сарын 05-аас 11 дүгээр сарын 05-ны хооронд зохион байгуулахаар дарга, эрхлэгч нартай холбогдож мэдээлэл өгсөн. Мөн тус сумын “Монгол бичгээ дээдлье” группт монгол бичгийн анхан шатны хичээлүүдийг цахимаар заан байршуулсан. 2022 оны 09-10 сарын хугацаанд тус сургуулийн монгол хэл, уранзохиолын багш нар сумын төрийн албан хаагчдын үндэсний бичгийн гарааны үнэлгээг тогтоож анхан шатны болон дунд шатны сураглтуудыг зохион байгуулсан. Мөн төрийн албан хаагчдад “Хүмүүн бичиг” сониныг захиалах уриалга гаргасан бөгөөд одоогийн төрийн албан хаагч захиалан уншиж байна. Жил бүрийн 05 сарын эхний долоо хоногт Бичиг соёлын өдрөөр төрөл бүрийн уралдаан тэмцээнүүдийг амжилттай зохион байгуулж шалгарсан иргэдийг аймгийн уралдаанд амжилттай оролцуулж хэвшсэн. 2024 он Ерөнхий боловсролын сургуулийн бүх албан</p>
--	--	--	--	--	--	--	--	--	--	--

										хаагчид Хүмүүн бичиг сонинг зохион уншиж Хүмүүн бичигтэн хамт олноор шалгарсан. Мөн багш бидний толь арга хэмжээг зохион байгуулж багш, ажилчдын бүтээлийг сургуулийн корторт байршуулсан. Мөн тус байгууллага нь Монгол бичгийг албан хэрэгт хөтлөн бусад байгууллагуудтай хос албан бичгээр харилцан ажиллаж байна.	
Бүлгийн дүн										84,7%	
1.5. Хүүхэд, залуучууд, гэр бүлийн хөгжил											
Зорилт 1. Гэр бүлд ээлтэй хөгжил, хамгааллын бодлогыг хэрэгжүүлэн гэр бүлийн хөгжлийг дэмжиж, тогтвортой, чадавхижсан гэр бүлийг төлөвшүүлнэ.	1	Гэр бүлийн тогтвортой байдлыг хангах зорилгоор мэргэжлийн байгууллагын хийсэн судалгаа, нотолгоонд тулгуурлан гэр бүлийн боловсрол олгох ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.	2021 - 2024	Нийгмийн бодлогын мэргэжилтэн		-	Сургалтад хамрагдсан гэр бүлийн тоо			Гэр бүлийн хүчирхийлэл бол гэмт хэрэг юм гэсэн хандлагыг төлөвшүүлэх зорилгоор “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” хуулиар зорилтот бүлгийн иргэдэд 1 удаа сургалтыг хийж мөн боршур тараалаа. Мөн цахимаар гэр бүлийн боловсрол олгох мэдээллийг байршуулан ажиллаж байна. Зорилтот айл өрхүүдээр нөхцөл байдлын үнэлгээ хийх явцдаа мэдээ, мэдээллийг өгч ажилласан. Гэр бүлийн хүчирхийлэл бол гэмт хэрэг юм гэсэн хандлагыг төлөвшүүлэх зорилгоор “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” хуулиар Цагдаагийн хэсэгтэй хамтран 1 удаа ерөнхий боловсролын сургуулийн 8-р дугаар ангийн эцэг эхчүүдийн дунд сургалт хийж боршур тараалаа. Мөн цахимаар гэр бүлийн боловсрол олгох мэдээлэл, хүүхэд хүмүүжлийн эерэг аргуудыг байршуулан ажиллаж байна.	70

									<p>Есөнзүйл сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй дуудлага мэдээлэл 108 тусгай утсанд хагас жилийн байдлаар суманд бүртгэгдээгүй байна. Хагас жилийн байдлаар гэр бүлийн хүчирхийлэл илрүүлэх арга хэмжээ авч ажиллах кейс шинээр нээгдээгүй байна. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хамтарсан баг нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн дагуу өдөр тутмын хамтарсан багийн үйл ажиллагаанд хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <p>2024 онд суманд насанд хүрээгүй хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртсөн тохиолдол байхгүй байна. Сургуулийн орчинд суралцагчийг үе тэнгийнхний дарамт, ялгаварлан гадуурхалтад өртөхөөс урьдчилан сэргийлэх 1 сарын аяныг зохион байгуулсан бөгөөд удирдамжийн дагуу, “Цахим орчны сөрөг нөлөөлөөс урьдчилан сэргийлэхэд хүүхэд бидний оролцоо” илтгэлийн уралдааныг зохион байгуулж нийт 24 хүүхэд оролцсоноос сурагч Б.Аундарь түрүүлсэн. Мөн “Дээрэлхэлтийн эсрэг хамтдаа тэмцье” гар зургийн уралдааныг зохион байгуулахад нийт 100 гаруй сурагчийн бүтээл ирсэн бөгөөд сурагчдаас санал асуулга авахад үе тэнгийнхний дээрэлхэлтийн хувь буурсан үзүүлэлтэй байна.</p> <p>“ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЛЭЭС УРЬДЧИЛАН</p>
--	--	--	--	--	--	--	--	--	--

									СЭРГИЙЛЭХ” хөтөлбөрийн хүрээнд Хамтарсан баг, Гэмт хэрэгээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл хамтран Дотуур байр, сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын үйл ажиллагаа, дотуур байрны анхан шатанд хөтлөгддөг баримт бичигт хяналт тавьж зөвлөн туслаж ажиллаа. Сурагчдын дунд хууль эрхзүйн сургалт, ахлах ангийн сурагчдад танин мэдэхүйн “АХА” тэмцээн зохион байгуулж бага ангийн сурагчдад чөлөөт цагаараа унших үлгэрийн ном гардуулан өгч ажиллаа.	
2	Залуу гэр бүлд чиглэсэн зөвлөгөө өгөх үйлчилгээг нэвтрүүлж, гэрлэлтийн үнэ цэнэ, гэр бүлийн үүрэг хариуцлагын талаарх ойлголтыг нэмэгдүүлж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэний нийгмийн байгууллагыг дэмжин хамтран ажиллана.	2021 - 2024	Нийгмийн бодлогын мэргэжилтэн		3.0 сая	Зөвлөгөө авсан гэр бүлийн тоо 30 гэр бүл		Сумын хэмжээнд залуучуудын нэгдсэн судалгааг гаргаж тухай бүр шинэчлэн ажиллаж байна. Сумын Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн А/100 дугаартай захирамжаар “Залуучуудын хөгжлийн зөвлөл”-ийг байгуулан хамтран ажиллаж байна. Залуучуудад гэр бүлийн үнэ цэнэ, үүрэг хариуцлагын талаарх ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор мэдээ мэдээлэл, видео, шторкуудыг цахим хуудаст байршуулан мэдээллийг хүргэж байна. Багийн иргэдийн нийтийн хуралаар залуу гэр бүл чиглэсэн өрхийн хэрэгцээ, аз жаргалтай гэр бүлийг бий болгох гэсэн сэдвийн хүрээнд танилцууллага бэлдэж залуу гэр бүлд тулгамдсан асуудлыг сонсож уг асуудлыг нэгтгэн Иргэдийн төлөөлөгчдийн хуралын даргад хүргүүлсэн.	70	

									Аймгийн засаг даргын ивээл дор зохион байгуулж буй "Гэр бүлийн үнэ цэнэ, өнөөгийн байдал" илтгэлийн уралдаанд 19 сумдын иргэд, төрийн албан хаагчдаас Есөн зүйл сумын Ерөнхий боловсролын сургуулийн монгол хэл, уран зохиолын Б.Цэцэгбадам багш манлайлан оролцож өнөөгийн гэр бүлд тулгарч байгаа олон асуудлыг хөндөж тус илтгэлийн уралдаанд амжилттай оролцсон. Сумын засаг даргын тамгын газраас дэмжин хамтран ажилласан.	
4	Гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, урьдчилан сэргийлэх, хүчирхийлэлд өртөгсдийг хамгаалах чиглэлээр төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллана.	2021 - 2024	Нийгмийн бодлогын мэргэжилтэн		11,2 сая	Нэг цэгийн үйлчилгээний төвөөр үйлчлүүлэгчийн тоо 8 эмэгтэйд 26 хүүхэд		Онцгой нөхцөл байдлын үед сумын "Хамтарсан баг"-ийн хүүхэд хамгааллын бэлэн байдлын үлгэрчилсэн төлөвлөгөө болон зураглалыг гарган баталгаажуулан төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна. Эрсдэлт нөхцөлд байж болзошгүй гэр бүл хүүхдүүдийн судалгааг гаргаж амьдралын байдалтай танилцаж, нөхцөл байдлын үнэлгээ хийж хамтарсан багийн хурлыг хийж үйл ажиллагааг төлөвлөн ажиллаж байна. Өндөр эрсдэлтэй архины хамааралтай хүчирхийлэл байж болзошгүй, амьжиргааны баталгаажих түвшин доогуур олон хүүхэдтэй өрх, харж хандах хүнгүй ахмад настан өрхийн гэрээр нь очиж нөхцөл байдалтай танилцлаа. Өндөр эрсдэлтэй 9 гэр бүлийн 41 хүүхдэд хүрч ажилласан байна. Багш айлчлал үйл ажиллагаагаар дамжуулан хүүхэд гэр бүлийн	90	

эрсдэлийг үнэлж, нуугдмал хүчирхийллийг илрүүлэн, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд гэр бүл дээр кейс нээж, кейс нээсэн тохиолдлын бүрдүүлэлт хариу үйлчилгээ авах хүрээнд: 2022-2023 оны хичээлийн жилд анги удирдсан багш нар “Багш айчлал” аргачлалын дагуу ангийн сурагчдын эрсдэлийн судалгааг нэгтгэж хамтарсан багаар сумын нэгдсэн судалгааг доорх чиглэлээр гаргасан.

- Бүтэн өнчин-3
- Хагас өнчин-49
- Хөгжлийн бэрхшээлтэй-9
- Айлд суудаг-88
- Бие даан амьдардаг-8
- Хурдан морь унадаг-30
- Сургууль завсардсан-4
- Эцэг эхийн хараа хяналт сул-4
- Хойд эцэгтэй-26, Хойд эхтэй-27 нийт дагавар хүүхэдтэй 53
- Тээврийн хэрэгсэл /мотоцикл/ жолооддог 13 сурагч байна.

Хүүхэд хамгааллын үйлчилгээнд гурван хүүхэд хүлээн авч нөхцөл байдлын үнэлгээ хийн 2022041201 Дугаартай кейс нээж эцэг эхэд гэр бүлийн тухай хууль, хүүхэд хамгааллын тухай хууль танилцуулж, анхан шатны сэтгэл зүйн зөвөлгөө өгч гэр бүлд бүлгийн ярилцлага хийн хамтарсан багаар үйлчилгээ төлөвлөн арга хэмжээг аван ажиллаж байна. Ар гэрийн

									гачигдлын улмаас сургууль завсардаж болзошгүй нэг сурагчийг сумын хамтарсан баг, хүүхэд хамгааллын багтай хамтран ажиллаж тус сурагчийг сургуульд холбон зуучилж, дотуур байранд 2 хүүхдийг авсан. Мөн сумын эрүүл мэндийн газартай хамтран нэг сурагчийг аймгийн БЭОТ-д үзүүлэхэд хөгжлийн бэрхшээлтэй нь батлагдсан. Мөн хүүхдийн тусламж 108 утсанд 2022 онд Гэр бүлийн хүчирхийллийн дуудлага мэдээлэл 2 бүртгэгдэн хамтарсан багийн ахлагчид мэдэгдэн хамтарсан багийг хуралдуулж гэр бүл хамгааллын хариу арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байна.	
Зорилт.3.Залуучуудын хөгжил, оролцоог дэмжсэн орчин нөхцөлийг бүрдүүлж, тэдний оролцоог хангах олон талт арга хэмжээг зохион байгуулж, нийгмийн идэвхтэй гишүүн болгоход дэмжлэг үзүүлнэ.	1	Залуучуудад бүх чиглэлээр хөгжих орчинг бий болгох зорилгоор “Залуучуудын хөгжлийн төв”-ийг шинээр байгуулан, стандартын дагуу тохижуулж, үйл ажиллагааг тогтмолжуулна.	2021	Нийгми		6.0 сая	Төвөөр үйлчилгээ авбал зохих залуучуудын тоо 12000		Төрөөс баримталж буй бодлогын баримт бичиг дээр үндэслэн Есөнзүйл сумын Залуучууд хөгжлийн зөвлөлийг 21 гишүүнтэйгээр байгуулж жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан ажиллаа.Залуучууд хөгжлийн зөвлөл байгуулсан хууль, эрх зүйн үндэслэл. Залуучууд хөгжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг сонгоход дараах төлөөлийг харгалзан үзсэн. Үүнд: төрийн болон төрийн бус, аж ахуйн нэгж байгууллага, өсвөр үе, оюутан, малчин, зорилтод бүлгийн залуучуудын төлөөлийг оруулж тус зөвлөлийг байгуулсан. ЗХЗ-ийн гишүүд YDC.mn сайтаар бүртгүүлж цахим батламж авлаа. Залуучууд хөгжлийн зөвлөл нь Залуучуудын хөгжил, оролцооны чиглэлээр	90

										<p>хөтөлбөр төлөвлөгөөгөө боловсруулан үйл ажиллагаа чанартай зохион байгуулахаар төлөвлөж байгаа юм. ЗХЗ-ийн дэргэдэх сан үүсгэж байгаа. Уг санг Залуучуудын авъас чадвар, бие бялдар, сэтгэхүйг хөгжүүлэхэд шашин болон улс төрөөс ангид урлаг, спорт, сургалтын арга хэмжээг зохион байгуулж, хуулийн этгээдтэй хамтран ажиллах, Залуу малчдыг хөгжүүлэх, соён гэгээрүүлэх ажлыг сумын бодлого, төлөвлөгөөнд тусгуулан үр дүнтэй зохион байгуулж ажиллах. Мөн сайн дурын оролцоонд тулгуурласан үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх. Залуучууд өсвөр үеийнхэнд байгаль орчинг хамгаалах, үндэсний өв уламжлалыг өвлүүлэх чиглэлээр төлөвлөгөөндөө тусгаж ажиллах, Залуучуудыг хорт зуршлаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөө боловсруулан залуучуудыг соён гэгээрүүлэх, оролцоог нэмэгдүүлэх чиглээр манай зөвлөл маань ажиллах болно. Залуучуудын цахим чуулганд 8 залуучуудыг оролцуулан үзэл бодолоо хуваалцах боломжоор хангалаа.14-35 насны хүмүүсийг залуучууд гэх бөгөөд манай суманд 917 залуучууд байгаагаас 503 эрэгтэй, 414 эмэгтэй залуучууд байна. Ахлах ангийн сурагчдад Монголын түүх, өв соёл, уламжлалыг сонирхолтой арга хэмжээ, багийн ажиллагаануудаар дамжуулан сурталчлах, хүүхэд</p>
--	--	--	--	--	--	--	--	--	--	--

									<p>залуусын тэгш оролцоог нэмэгдүүлэн хангаж, байгаль орчиноо хайрлан хамгаалах чадварыг олгох, цаашлаад шийдвэр гаргалтад залуусын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор зохион байгуулагдаж буй "Youth power Өвөрхангай-2024" байгальд ээлтэй хүүхэд залуучуудын чуулга уулзалтыг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр Хужирт суманд зохион байгуулахдаг уулзалтад Есөнзүйл сумын Ерөнхий боловсролын сургуулийн ЕКО-КЛУБ-ийн 5 сурагч болзол журамыг ханган хүүхдийн элч Б.Мягмарчулуун багштай хамран шаардагдах төсөв зардлыг гарган тус чуулганд сурагчдыг хамруулан ажиллаа. Өвөрхангай аймгийн Засаг даргын Тамгын газар, Монголын Залуучуудын Холбоо НҮТББ-тай хамтран Монголын Залуучуудын холбооны "Оролц, Нөлөөл, Манлайл" уриан дор Монгол улсын хэмжээнд зохион байгуулагдаж буй 7 бүсийн чуулганы Хангайн бүс чуулганд сумын залуучуудын оролцоог ханган Төсөвт 4 байгууллага, малчин залуусын төлөөлөл залуу үеийг сонгон 2024 оны 05 дугаар сарын 08, 09-ний өдөр Өвөрхангай Арвайхээр хотод тус чуулганд холбогдох зардлыг гарган залуусын оролцоог ханган ажиллав.</p>	
Бүлгийн дүн									80%	
1.7. ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ										

<p>Зорилт 1. Хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэрт байдлыг хангаж, халамжаас хөдөлмөр эрхлэлтэд шилжүүлэх замаар ажилгүйдлийн түвшинг бууруулж, нийгмийн дундаж давхаргыг нэмэгдүүлнэ.</p>	1	<p>Орон нутгийн нийгэм, эдийн засгийн бодлогод тулгуурлан, салбар бүрт шинээр бий болох ажлын байрыг төлөвлөн, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого, төсөл хөтөлбөр, хөнгөлөлттэй зээлд хамруулан, ажилд зуучлах замаар 8.0 мянгаас доошгүй ажлын байр бий болгоно.</p>	2020 - 2024	ХХҮмэр гэжилтэн		-	1500 ажлын байр шинээр бий болгосон		<p>Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс баталсан төсөл хөтөлбөрийн талаар иргэдэд мэдээлэл өгч ажиллаа. 2 удаа 58 иргэнд хөтөлбөрийн талаар сургалт зохион байгуулсан. Сумын ЗДТГ-ын мэдээллийн самбарт дэлгэрэнгүй мэдээлэл тавьж ажиллаа. Мөн хөтөлбөрийн талаарх мэдээллийг цахим мэдээллийн сувгуудаар иргэдэд хүргэн хөтөлбөрт хамрагдсан иргэдийн ур чадварт үнэлгээ хийн ажиллаж байна. Шинэ ажлын байранд 49 иргэнийг бүртгэж, түр байнгын ажлын байр 14, байнгын ажлын байр 35 бий болсон. 32 иргэнийг ажлын байранд зуучилсан.</p>	100
	5	<p>Эмэгтэйчүүд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөдөлмөр, эрхлэлтийг дэмжих сангийн зээл, төсөл, хөтөлбөрт хамруулан хүн амын бүлгүүдийн онцлогт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.</p>	2020 - 2024	ХХҮмэр гэжилтэн		558,1 сая	700 иргэнийг төсөл, хөтөлбөрт хамруулсан байна		<p>Малжуулах хөтөлбөрт 11 эмэгтэй, ХЭДС-ийн жижиг зээлийн төсөлд 3 эмэгтэй, Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний бүлийн төсөлд 2 эмэгтэй хамрагдаж ажлын байртай болсон. Мөн албан газар, аж ахуйн нэгж байгууллагад 12 эмэгтэй ажилд зуучлагдан орсон. Мөн нийтийг хамрсан ажилд 8 эмэгтэй, ямаа самнах ажилд 4 эмэгтэй хамрагдаж түр ажлын байраар хангагдан өрхийн орлогоо нэмэгдүүлж ажилласан. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх хөтөлбөрт 1 эмэгтэй хамрагдан ажлын байртай болсон ахмад настны санхүүгийн дэмжлэгт 1 ахмад, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд 1 ахмад настан хамрагдаад байна.</p>	100

<p>Зорилт 2. Салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган, төр, хувийн хэвшлийн байгууллагууд, ажилтан, үйлчлүүлэгчдэд ээлтэй орчин бүрдүүлнэ.</p>	1	<p>Сумдын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл, Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссын гишүүдийг чадавхижуулна.</p>	2020 - 2024	ХХҮмэр гэжилтэн		-	5 удаа		<p>Байгууллага бүр ХАБЭА-н ажилтантай. ХАБЭА-н хүрээнд төрийн байгууллагын мэдээ мэдээлэл, Есөнзүйл сумын зарын нэгдсэн группүүдээр зааварчилгаа шторкыг байршуулан ажилласан. Мөн сумын болон албан газруудын ХАБЭА-н ажилтнууд цахимаар 2 удаа сургалтанд хамрагдсан. Сумдын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл, Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссын гишүүдийг чадавхижуулах сургалтанд аймгийн ХХҮГ-аас зохион байгуулсан 2 удаагийн онлайн сургалтанд 8 гишүүн 2 удаа сургалтанд хамрагдсан. ХХҮГ-аас ирүүлсэн гарын авлага боршурыг гишүүдэд тарааж олгосон.</p>	100
<p>Зорилт 3. Нийгмийн халамжийн үйлчилгээг оновчтой болгон, зорилтот өрх, иргэний амьжиргаанд дэмжлэг үзүүлж, амьдралын чанарыг дээшлүүлнэ</p>	2	<p>Зорилтот бүлгийн өрхүүдийн дунд бүлэг, хоршоо байгуулан, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээгээр дэмжин ажиллана.</p>	2020 - 2024	ХХҮмэр гэжилтэн		34,5 сая	10 бүлэгт		<p>Байгууллага бүр ХАБЭА-н ажилтантай. ХАБЭА-н хүрээнд төрийн байгууллагын мэдээ мэдээлэл, Есөнзүйл сумын зарын нэгдсэн группүүдээр зааварчилгаа шторкыг байршуулан ажилласан. Мөн сумын болон албан газруудын ХАБЭА-н ажилтнууд цахимаар 2 удаа сургалтанд хамрагдсан. Сумдын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл, Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссын гишүүдийг чадавхижуулах сургалтанд аймгийн ХХҮГ-аас зохион байгуулсан 2 удаагийн онлайн сургалтанд 8 гишүүн 2 удаа сургалтанд хамрагдсан. ХХҮГ-аас</p>	100

									ирүүлсэн гарын авлага поршурыг гишүүдэд тарааж олгосон.	
3	“Нэг өрх - Нэг ажлын байр” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар нийгмийн халамжийн дэмжлэг тусламж зайлшгүй шаардлагатай өрхийн тоог бууруулна.	2017 - 2020	ХХҮмэр гэжилтэн		193,8 сая	-			“Нэг өрх - Нэг ажлын байр” хөтөлбөрт хамрагдах 12 өрхийг сонгон судалгаа тоон мэдээллүүдийг гарган аймгийн Нийгмийн бодлогын хэлтэст хүргүүлсэн. Хөтөлбөрт хамрагдсан өрхийн 8 иргэн нийтийг хамарсан ажилд хамрагдсан "Нэг өрх-Нэг ажлын байр" хөтөлбөрт хамрагдсан өрхөөс байнгын ажлын байранд 9 иргэн түр ажлын байранд 12 иргэн хамрагдсан. Малжуулах хөтөлбөрт 3 өрх хамрагдаж 6 иргэн байнгын ажлын байртай болсон.	100
4	Нийгмийн халамжид хамрагдахад шаардагддаг материалыг цахимаар хүлээн авч, иргэдэд шуурхай үйлчилнэ.	2020 - 2024	ХХҮмэр гэжилтэн		-	16 төрлийн үйлчилгээ			Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, хөнгөлөлт тусламжид хамрагдах хүсэлт ирүүлсэн иргэдийн материалыг хүлээн авч тухай бүрт нь цахим системд бүртгэн ХХҮГазар хүргүүлэн ажиллаж байна. . Тайлангийн хугацаанд Нийгмийн халамжийн ehalamj.mn программаар 2616 иргэний үйлчилгээг шивж хүүхдийн мөнгө болон тэтгэвэр тэтгэмж хөнгөлөлт үйлчилгээг үзүүлээд байна. Тайлангийн хугацаанд 268 ахмад настан, 72 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хөнгөлөлт, тусламжийг олгосон. Мөн харьяалалгүй 266 ахмад настанд 2 удаа хүндэтгэл үзүүлсэн. 306 ахмад настанд Насны хишгийн тэтгэмжийг олгоод байна.Нийгмийн халамжийг тэтгэврийг 34 иргэнд, асаргааны тэтгэмжийг 128 иргэнд, жирэмсний тэтгэмжийг 48 эхэд, 0-3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа	100

									эх/эцгийн/ тэтгэмжийг 149 иргэнд тус тус олгоод байна. Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах иргэдийн үйлчилгээг ehalamj.mn-программд бүртгэн олголт үүсгэн ажиллаж байна.Нийгмийн халамжийн бүх үйлчилгээ цахимжсан.	
Зорилт Нийгмийн даатгалын мэдээллийг бүрэн цахимжуулан, иргэд даатгуулагчдад үйлчилгээг ил тод, шуурхай хүртээмжтэй хүргэх, хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчдыг нийгмийн даатгалд хамруулж, тэдний нийгмийн баталгааг хангана.	4.	1	Нийгмийн даатгалын цахим мэдээллийн сан бүрдүүлж, архивын цахим лавлагааны үйлчилгээг жигдрүүлж, иргэд даатгуулагчдад шуурхай үйлчилгээ үзүүлнэ.	2020 - 2024	Нийгмийн даатгалын байцаагч			1500	Нийгмийн даатгалын мэргэжилтэн Ажил олгогч, иргэд, даатгуулагчид нийгмийн даатгалын архивын үйлчилгээг чирэгдэлгүй үзүүлж байгаа. “Архивын лавлагаа авах” тухай хүсэлтийг тухай бүр нь арга хэмжээ авч ажилласан. “ https://www.facebook.com/esunzuil.daatgal ” гэсэн цахим хаяг нээн иргэд даатгуулагчийг урьж одоогоор 320 гишүүнтэй болж өргөжин цахимаар мэдээ мэдээлэл хүргэн ажиллаж байна. Иргэд даатгуулагчдад нийгмийн даатгалын хууль тогтоомжид орсон өөрчлөлт, цахим эмнэлгийн хуудас болон цахим дэвтрийн талаар мөн нийгмийн даатгалын аппликейшнийг суулгах заавар зөвлөмж өгч, суулгаж өгч ажиллаж байна. Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаа цахимжиж байна. Даатгуулагчид шимтгэл төлөлт, нэрийн данс, тэтгэвэр, тэтгэмжийн үйлчилгээ авах, нийгмийн даатгалын тодорхойлолт авах зэрэг үйлчилгээнүүдийг цахимаар авч байна. Мөн тэтгэврийн хувийн хэргийг цахимжуулах үйл ажиллагаа 100 хувь хийгдсэн. 2024 оны 01 сарын 01-ээс малчдын	100

									нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг 50% хөнгөлж байгаатай холбогдуулан иргэд малчдад хуулийг сурталчилж хамралтыг нэмэгдүүлж байна. Нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмжийн үйлчилгээ цахимжиж иргэд цахим хэлбэрээр үйлчилгээ авч байна.	
2	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлж, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон малчдын нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлнэ.	2020 - 2024	Нийгмийн даатгалын байцаагч			30065. 4			Нийгмийн даатгалын мэргэжилтэн Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө 2021 онд 230928,1 гүйцэтгэл 305448,2 буюу 132,3 % тай биелэсэн байна. Сайн дурын даатгалд 350 хамрагдахаас 198 иргэн хамрагдаж хамралт 56,5%, төлөвлөгөө 115723 гүйцэтгэл 48194 буюу 41,6%-тай байна. /Эхний 9 сарыны байдлаар/ Малчдыг сайн дурын даатгалд хамрагдах талаар давхардсан тоогоор 450 иргэнд сурталчилгаа хийж 150 ширхэг боршуур мэдээллийг хувиан хүргүүлсэн зэрэг сайн дурын даатгалд хамрагдах иргэдийн хамрагдалтыг нэмэгдүүлэх, орлогын төлөвлөгөөг биелүүлэх талаар арга хэмжээ авсан. Төсвийн шууд захирагчтай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд заасныг хэрэгжүүлэх зорилгоор нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг журам, зааврын дагуу сар бүр хуваарилан төвлөрүүлж ажилласан ба шимтгэлийн орлогын биелэлтийг ханган ажиллаж байна. Оны эхнээс БИНХурлаар 500 орчим иргэдэд мөн 1, 3, 4 дүгээр багийн 164 айл өрхийн 308 малчид иргэдэд 6 удаагийн сургалт, зөвөлгөө,	100

										<p>мэдээлэл өгч ажиллалаа. Мөн Сумын малчидын зөвлөгөөнөөр 185 малчинд мэдээлэл хүргэж ажилласан. Энэ жилийн байдлаар давхардсан тоогоор сумын нийт хүн амын 1000 орчим иргэд малчид, даатгуулагчдад мэдээлэл хүргэж ажиллалаа. Төсвийн шууд захирагчтай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд заасны дагуу тус суманд оны эхэнд 6 төсөвт байгууллага, 12 аж ахуй нэгж байгууллага үйл ажиллагаа явуулж даатгуулагчийн нийгмийн баталгааг хангах зорилгоор шимтгэл төлж байгаа бөгөөд энэ онд 2 ААН шимтгэл төлж одоо нийт 6 төсөвт байгууллага, 14 аж ахуй нэгж байгууллага шимтгэл төлж байна. Иргэд даатгуулагчдад мэдээ мэдээлэл сургалтыг хийснээр даатгуулагдын тоо нэмэгдэж байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг хангаж ажиллаж байна. хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор оны эхнээс БИНХурлаар 232 иргэнд мөн 1,2, 3, 4 дүгээр багийн 74 айл өрхийн 150 орчим малчид иргэдэд сургалт, зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллалаа. Мөн Аж ахуйн нэгжүүдээр болон малчин айлуудаар явуулын үйлчилгээ үзүүлж малчид болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд сайн дурын даатгал, тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэндийн талаар мэдээлэл өгч иргэдийн ажилласан жилийг тооцон зөвлөгөө өглөө. 2023 оны 10 сарын байдлаар сайн дурын даатгалын шимтгэлийн</p>
--	--	--	--	--	--	--	--	--	--	---

										орлого 49%, албан журмын даатгалын орлого 158%, нийгмийн даатгалын сангийн нийт орлого 115%-иар биелээд байна. 2024 оны 01 сарын 01-ээс малчдын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг 50% хөнгөлж байгаатай холбогдуулан иргэд малчдад хуулийг сурталчилж хамралтыг нэмэгдүүлж байна.	
Бүлгийн дүн										100	
Бүлгийн дундаж										90,7%	

ХЯНАСАН: ЕСӨНЗҮЙЛ СУМЫН ЗАСАГ
ДАРГА Т.БАТ-ӨЛЗИЙ

ТАЙЛАН НЭГТГЭСЭН: ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Т.МӨНХЗУЛ